



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.11.16, БААСАН ~ №224 (1023)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Валютын нөөц бүрдүүлэх Төв банкны ачаанаас Засгийн газар үүрэлцэнэ

Улсын төсөв мөнгөний бодлоготой 100 хувь уялдах шаардлагагүй гэв.

>2

FT ШИЛДЭГ

НИЙТЛЭЛҮҮД ТАНД ХҮРЧ БАЙНА

>9, 10

Эм таргалуулдаггүй, харин галбир өөрчилдөг

Дааврын бэлдмэлтэй эм таргалуулдаг гэдэг нь нотлогдоогүй.

>5

ZGM DAILY

FULL ENGLISH PAGE INSIDE

>7

ОНЦЛОХ

УЛС ТӨР
МАН-ын бүлгийн гишүүдийн эв нэгдлийг хангаж ажиллана гэж Д.Тогтохсүрэн мэдэгдлээ.
Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар Г.Билгүүн томилжээ.
Нотариатын хуулийн хэрэгжилтийг түдгэлзүүллээ.
Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын 2019 оны төсөвт бүхэлд нь хориг тавив.

ЭДИЙН ЗАСАГ
"Цемент шохой" компанийн хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлээ.
ДНБ-ий өсөлт III улиралд сүүлийн дөрвөн жилийн дээд түвшинд хүрлээ.
"Минжпроперти" нэг жилийн хугацаатай, нэг тэрбум төгрөгийн бонд гаргана.
Топ 20 индекс 1.07 хувиар буурч, 20143.71 нэгжид хүрэв.



НИЙГЭМ
Согтуурах, мансуурах донтой хүнээр албадан хөдөлмөр эрхлүүлж байхаар болов.
Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төв шинэ байртай боллоо.
Дугуй, хог шатаан агаар бохирдуулж буй хүнийг 50 мянгаас нэг сая төгрөгөөр торгоно.
Энэ жил бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн 89.5 хувийг базаагаад байна.

ДЭЛХИЙ
АНУ машины импортод тариф тогтоовол ЕХ хувиар арга хэмжээ авахаа мэдэгдсэн байна.
Филиппин улс Өмнөд Солонгосоос хуванцар нэрээр оруулсан хогийг буцаахыг шаардав.
Британийн эрүүл мэндийн салбар Брекситийн дараа 350 мянган хүнээ цомхотгоно.
Хүйтэн өвөл болох мэдээг дагаад АНУ-д байгалийн хийн фьючерсийн үнэ 18% өслөө.
Мьянмар улс Бангладешаас рохинжа дүрвэгсдийг буцаан ирүүлэх ажлыг эхлүүлжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
 2018.11.16

-5° | **-14°**

ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭГЖЭЭНИЙГ МЭДЭЭЛЛИЙГ 6 ДУГААР НУУРГУУС УНШИНА УУ.

8 658 000 029112 01023

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

“ДЦС-4” ДЭЛБЭРЧ МЭДЭХ АЮУЛААС АВРАГДЖЭЭ



Энэ сарын 11-ний өдөр Шивээ-Овоогоос “ДЦС-4”-т нийлүүлдэг нүүрсэн дотроос тэсрэх бодис илэрчээ. Дуудлагын дагуу онцгой байдлын албаныхан очиж аюулгүй болгосон байна. Хэрэв станцын ажилчид тэсрэх бодисыг анзаараагүй бол зуух руу ороод юу болохыг хэн ч таашгүй. ▶ 4

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

“Тавантолгой”-н IPO хөрөнгө оруулагчдын анхаарлын төвд байна

Б.Баяртөгтох
 @bayartogtokhZGM

“Эрдэнэс Тавантолгой”-г олон улсын компани болгох эрэлд Засгийн газар гарсан. 180 хоногт багтаан хөрөнгө оруулагчдад хувьцаагаа санал болгох бэлтгэл ажлаа тус компани бүрэн гүйцэд хангаж, үүний дараа IPO хийх юм. Ингэснээр шаардлагатай төслүүдээ санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэртэй болно. “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” тогтоолыг батлуулж, гацаанд байсан “Тавантолгой” төслийг хөдөлгөж чадсан нь Д.Сумъяабазарын гавьяа болж байна. Гэхдээ энэ бол дөнгөж эхлэл.

“Эрдэнэс Тавантолгой”-н нийт хувьцааны 30 хүртэлх хувийг олон улсын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах бэлтгэл ажил энэ зуны турш үргэлжилсэн, одоо ч үргэлжилж байна. Тус компанийн засаглалыг сайжруулах Олон нийтийн зөвлөл хүртэл байгуулагдаад буй.

▶ 3

FT

Бангладеш оёдлын салбарт Хятадыг орлож чадах уу

Мицури Обе

Нийслэл Дака хотоос урагш хоёр цаг давхихад хүн тэрэг хөлхөх гудамжуудад хувцасны орчин үеийн үйлдвэрүүд ноорхой мухлагууд дундаас содон үзэгдэнэ. Шинэхэн ганц үйлдвэр өрнөдийн зах зээлд зориулан Шведийн H&M, Британийн Marks&Spencer гэх мэт загварын 240 мянган эрэгтэй хослолыг нэг сард гаргах хүчин чадалтай. Universal Menswear компанийн оёдлын үйлдвэрийн дарга Четия Жаяакоди “Бид гараар эсгүүр хийдэг байсан. Одоо машин ашиглаж байгаа. Урьд нь 15 хүний хийдэг байсан ажлыг одоо хоёр эсгүүрчин амжуулдаг. Бас бүрэн автоматжсан оёдлын машинтай болсон. Ажилчин чадвар муутай байсан ч машин бүгдийг чадна” гэв.

Эдний 4800 ажилчны 85 хувь нь эмэгтэй бөгөөд хослол оёх ямар ч туршлагагүй авч энэ нь ноён Жаяакодийн хувьд бэрхшээл биш гэнэ. Ашиглалтад ороод зургаан жил болсон нарийн ажиллагаатай үйлдвэрийг барихад 35 сая ам.доллар зарцуулжээ.

▶ 9

ЭДИЙН ЗАСАГ

Гамшигт өртсөн гурван жижиг бизнес тутмын нэг нь дампуурдаг

Г.Байгал
 @baigalZGM

Өмнийн говьд өнгөрсөн зун их хэмжээний хур тунадас унахад А компани түлшгүй, тээвэрлэлт ч үгүй, борооны устай зууралдсаар цөөнгүй хоножээ.

Харин үерээс хамгаалах далан барьсан Б компани энэ үеэр хэвийн ажиллаж, борооны усаа хуримтлуулаад, баяжуулах үйлдвэртээ ашигласан байна. Нэг салбарын хоёр компани эрсдэлийн эсрэг ийм эрс тэс байсан нь хол зөрүүтэй үр дүн дагуулжээ. Төрийн өмчит А компани байгаль цаг уурын эрсдэлийг үл тоосноос нүүрсний тээвэрлэлтээ гацааж, орд уурхайгаа үерт автуулахад хүргэсэн бол Б компани байгалийн гамшигийг давуу тал болгон ашигласан нь энэ.

▶ 12



АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
1214.23 0.28%	6090 0.28%	95.340 0.10%	108.04 0.06%	97.870 0.29%	2569.63	370.38	38.57

Улс төр

ПАРЛАМЕНТ

Валютын нөөц бүрдүүлэх Төв банкны ачаанаас Засгийн газар үүрэлцэнэ

Улсын төсөв

мөнгөний бодлого-той 100 хувь уялдах шаардлагагүй гэв

Б.Энхжаргал
@enkhjrglZGM

Монголбанк мөнгөний бодлогоороо дамжуулан инфляцыг найм орчим хувьд тогтворжуулах зорилтыг ирэх хоёр жил үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр УИХ баталлаа. Харин дунд хугацаандаа зургаан хувь болгон бууруулах аж.

“Гадаад эрэлт, түүхий эдийн үнэ өндөр байгаа энэ үед эдийн засгийн идэвхжил, ажил эрхлэлтийг бүх салбарын түвшинд дэмжихийн зэрэгцээ инфляцын хүлээлтийг тогтворжуулах нь чухал ач холбогдолтой. Инфляц 2018-2019 онд зорилгот түвшний орчим хадгалагдах боломжтой” гэж төв банкны төлөөлөл танилцуулав.

Харин валютын нөөцийг бүрдүүлэх үүргийг төв банк дангаар хүлээхгүй. Төрийн эрх барих бусад байгууллага тэр дундаа Засгийн газартай хамтран хэрэгжүүлэх байдлаар Үндсэн чиглэлд тусгасан аж. Тодруулбал, УУХУЯ, ГХЯ, ЗТХЯ зэрэг салбарын яамдууд голлон анхаарна.

Монгол Улс жил гаруй хугацааны дараа томоохон бондуудын эргэн төлөлтийг хийнэ. Гадаад өрийн эх үүсвэрийг бүрдүүлэхийн тулд валютын нөөцийг бүрдүүлэх ёстой. Зөвхөн өр төлөхөөс гадна гадаад эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулах, улс орны эдийн засгийн дархлааг сайжруулах, гадаад секторын тэнцвэртэй байдлыг хадгалахад валютын улсын нөөцийг зохистой түвшинд хүргэж нэмэгдүүлэх шаардлага бий гэж Монголбанкныхан тайлбарлаж байлаа.

Мөнгөний бодлогын эцсийн хэлэлцүүлгийг хийх үеэр УИХ-ын гишүүн Б.Жавхлан “Төсөв болон мөнгөний бодлого 100



Ирэх оны мөнгөний бодлогод чангарах төлөв давамгайлахаар байна.

Б.Хасуй / ЗГМФ

хувь уялдах шаардлагагүй. Харин алсуураа энэ хоёр бодлого бие биенийхээ зорилтыг дэмжиж байх ёстой. Мөнгөний бодлогын хувьд мөчлөг сөрсөн байдлаар тэнцэл анх удаа тэрбум ам.доллар давсан эерэг дүнтэй байна. Ийм нөхцөлд мөнгөний бодлого хэрэгжих юм. Эдийн засаг тэлэхийн хэрээр инфляц дээр ирэх дарамт нэмэгдэнэ. Одоо ч бараг найман хувь дээр ирчихсэн байгаа учир ирэх оны мөнгөний бодлогод чангарах төлөв давамгайлах болов уу” хэмээв.

УИХ-ын чуулганы хуралдаанаар мөн Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцлээ. Үүнтэй хамт

“Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн талаар авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцсэн юм.

УБТЗ-ын төлсөн татварын зээлийн алданги, хүүгийн төлбөрөөс суутгана

Монгол Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийг үүсгэн байгуулах тухай 1949 оны хэлэлцээрт төмөр замын барилга ашиглалтад чухал хэрэглэгдэх төхөөрөмж, материалуудыг шалгах үзэх, гааль, татвар хураахгүй Бүгд Найрамдах Монгол Ард Улсад нэвтрүүлэх үүргийг хүлээсэн байна.

Гэвч “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн удирдлагууд 1998 оны долдугаар сарын 01-нээс есдүгээр сарын 30-ны хооронд төлсөн НӨАТ-ыг Гаалийн Ерөнхий газрын

нэхэмжилсэн 167.0 сая төгрөгийг дизель түлшний онцгой албан татвар суутган тооцох хүсэлтийг гаргасан. Энэ үеэс эхлэн тус нийгэмлэг өөрийн хэрэгцээнд импортлон оруулж байсан технологийн зориулалттай дизелийн түлш, автобензинд албан татвар болон онцгой албан татварыг улсын төсөвт төвлөрүүлдэг болжээ. 1998-2015 оны хооронд зөвхөн дизель түлшний онцгой албан татвар 73.8 тэрбум төгрөг төлсөн байна.

Харин 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус нийгэмлэгийг онцгой албан татвараас чөлөөлсөн байна.

Тиймээс 1998-2015 онд импортсон дизель түлшний онцгой албан татварт төлсөн 73.8 тэрбум төгрөгийг “Олон улсын хамтын ажиллагааны Японы банк”-наас төмөр замын тээврийг сэргээн сайжруулахад зориулж олгосон МОН-П1, МОН-П2 хөнгөлөлттэй зээлийн гэрээний дагуу тооцсон алданги, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөөс суутган тооцох арга хэмжээ авахгүй бол тус нийгэмлэгийн тээвэрлэлтийн үйл ажиллагаа зогсох хүртэл эрсдэл үүсч болзошгүй болсон гэж төсөл санаачлагчид үзжээ. Улмаар гишүүдийн олонх нь дээрх төслүүдийг дэмжив. [ЗГМ]

БҮЛЭГ

Д.Эрдэнэбат: УИХ, Засгийн газрын хариуцлагатай холбоотой бидний шаардлага хэвээр байгаа

Б.Сэлэнгэ
ЗГМ

УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Эрдэнэбат цаг үеийн байдалтай холбоотой зарим асуултад хариулт өглөө.

–Засгийн газрыг огцруулах асуудал ид өрнөж байна. УИХ дахь Ардчилсан намын бүлэг энэ талаар ямар байр суурьтай байгаа вэ?

Өнөөдрийн төр засагт авлига, аллага, хулгай нүүрлэнхлээ. Тийм учраас Засгийн газарт хариуцлага тооцох шаардлагатай гэсэн байр суурийг УИХ дахь Ардчилсан намын бүлэг удаа дараа УИХ-ын дарга, Засгийн газарт илэрхийлсэн. Сүүлийн үед өрнөж байгаа МАН-ын дотоод асуудалд Ардчилсан нам оролцохгүй байгаа. Учир нь эрх баригчдын дотоод асуудал хямралын цэгтээ хүрэхээс өмнө бид өөрсдийнхөө байр суурийг тодорхой илэрхийлсэн. Энэ байр суурь өнөөдрийг хүртэл хэвээр байгаа. Дараагийн анхаарал татаж байгаа сэдэв УИХ-ын өөрийнх нь үйл ажиллагаа болон 60 тэрбумын асуудлаар тавьсан бидний шаардлага ч мөн хэвээр байгаа. Төр засгийн үйл ажиллагаа болохоо байчихлаа, шударга бус үйлдлүүд хэрээс хэтэрчихлээ нэг тийш нь шийдэх ёстой гэсэн ард түмний шаардлагатай манай бүлгийн шаардлага нийцэж байгаа учраас бүлгийнхээ хурлыг яаран хийхгүй. Ер нь бол бидний



шаардлага хэвээрээ гэдгийг ойлгох хэрэгтэй.

– УИХ-ын гишүүн Д.Хаянхярваа Засгийн газрыг огцруулахаар яг 26 гишүүн гарын үсэг зурсан гэсэн. Та бүхэн нэмж кноп дарах уу?

–Засгийн газраа хэрхэх нь эрх баригчдын асуудал. Тэнд хэдэн хүн яаж гарын үсэг зурсан нь чухал биш. Хамгийн гол нь хариуцлага тооцох нь л чухал.

Өмнө нь хэлж байсан үгээ дахиад нэг хэлье. 2016 оны сонгуулиар өнөөдрийн эрх баригчдад үнэмлэхүй олонхийн

саналыг ард түмэн итгэж өгсөн. Энэ итгэл мөхөж байгаа нь тун харамсалтай. Монгол Улсын хувь заяа эрх баригчдын гарт байгаа гэдэг ойлгох хэрэгтэй.

–Хэрэв Засгийн газар огцроод танай намтай хамтарсан Засаг байгуулах санал тавьбал хүлээж авах уу?

–Тийм юм байхгүй ээ. Есөн гишүүнтэй бүлэг хамтарна гэж юу байх вэ. Нэгэнт ачаагаа үүрсэн бол бариад хүртлээ үүрч явах эсэхээ эрх баригчид өөрсдөө л шийд гэсэн байр суурийг АН-ын бүлэг илэрхийлж байгаа. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ХОРИГ

Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль болон дагалдан батлагдсан хуулиуд, УИХ-ын тогтоолуудад бүхэлд нь хориг тавилаа. Хоригоо Ерөнхийлөгч Х.Баттулга өөрөө Улсын Их Хурлын дарга М.Энхболдод өргөн барьсан аж.

» ЦЭЦ

Нотариатын хуулиар өвлөгдөх эд хөрөнгө барьцаанд байгаа нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг уг эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн өвлөгчид олгохоор тусгасан байна. Гэвч энэ нь өмчлөгчийн хүсэл зоригийн дагуу бусдаас хараат бусаар хэрэгжих өмчлөх эрхэд хязгаарлалт тогтоосон гэж Үндсэн хуулийн цэцээс үзэж дээрх хуулийг түдгэлзүүлснийг УИХ хүлээж авав.

» ШҮҮХ

УДШ-ийн шүүгчид С.Соёмбо-Эрдэнийг нэр дэвшүүлжээ.

» ТОМИЛГОО

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар Г.Билгүүнийг томилжээ. Г.Билгүүн нь төрийн албанд 15 дахь жилдээ ажиллаж байгаа бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яаманд мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга, газрын дарга, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Архивын ерөнхий газрын дэд даргаар ажиллаж байсан аж.

» ХУУЛЬ

Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийг шинэчилж, баталлаа. Гол өөрчлөлт нь сэтгэцийн эмчилгээтэй хамааралгүй, харин Төв аймгийн Мааньт дахь албадан эмчилгээтэй холбоотой зохицуулалт аж.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: “Агаар орчны бохирдлыг бууруулах техник, технологийн төв байгуулах” үл хөдлөх хөрөнгө нийлүүлэх ажил
Тендер шалгаруулалтын дугаар: НХААГ-18/0099

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендер оролцогчдоос “Агаар орчны бохирдлыг бууруулах техник, технологийн төв байгуулах” үл хөдлөх хөрөнгө нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендер оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50 000 (тавин мянга) төгрөгийг банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн дотор хүчинтэй байна.
Тендер нь дараах багцаас бүрдэнэ: **Багцгүй.**
Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ:

Сүүлийн 3 жилийн (2015, 2016, 2017 он) дундаж борлуулалтын хэмжээ нь тендер санал болгож буй үнийн 50 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Тендер санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:

Сүүлийн 3 жил буюу 2015, 2016, 2017 оны жилийн эцсийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ.

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:

Сүүлийн 3 жил буюу 2015, 2016, 2017 оны аль нэг жилд тендер санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байх.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Үгүй**

Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ.

3 000 000 /гурван сая/ төгрөг

Тендерийг 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 10 цаг 30 минутаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 цаг 00 минутад Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг www.tender.gov.mn, www.ub-procurement.mn цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15, Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 дугаар давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757810

Нийтлэлчийн булан



Ирэх оны эхний хагаст “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцаа олон улсын хөрөнгө оруулагчдын хүртээл болох юм.

С.Батсайхан / ЗГМӨ

“Тавантолгой”-н IPO хөрөнгө оруулагчдын анхаарлын төвд байна

“Эрдэнэс Тавантолгой” засаглалаа сайжруулахаар бодит алхмыг хийж эхэллээ

Анх удаа төрийн өмчит аж ахуйн нэгж дэргэдээ ийм зөвлөлтэй болсон нь энэ. Өмнө нь хаалттай байсан ажлын байрны зарыг тогтмол мэдээлж, нээлттэй сонгон шалгаруулалтаар ажилд хүмүүс авч байна. Мөн нүүрс худалдан авагчийг нээлттэй тендерээр сонгон шалгаруулж, борлуулалтын гэрээг нь ил

болголоо. Энэ бүхэн “Эрдэнэс Тавантолгой”-н IPO-г үр дүнтэй болгоход чиглэж буй хэрэг.

Монголын нүүрсний экспортын гуравны нэгийг дангаар бүрдүүлж байгаа тус компани хүчин чадлаа нэмэгдүүлж, дэд бүтцийн асуудлаа шийдвэрлэхэд нийт 7.1 тэрбум ам.доллар шаардлагатай. Үүний 30 гаруй хувийг олон улсын хөрөнгийн зах зээлээс босгохоор зорьж байгаа нь энэ. УИХ, Ерөнхийлөгчийн зүгээс дэмжлэг хүлээж, улс төрийн ямар нэгэн эрсдэлгүй урагшилж яваа “Тавантолгой” төсөл амжилттай хэрэгжихэд “Эрдэнэс Тавантолгой”-н үүрэг, роль их. Компанийн засаглалын наад захын шаардлагыг хангахгүй бол олон улсын биржүүдийн босго давахад бэрх. Тиймээс бэлтгэл ажлын хүрээнд компанийн Төлөөлөн

дирдах зөвлөлийг чанаржуулж, хувьцаа эзэмшигчдийн итгэл даах хэмжээний мэдлэг боловсролтой, туршлагатай нэгэнд энэ үүрэг, хариуцлага ногдох учиртай.

“Эрдэнэс Тавантолгой”-н хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирц есдүгээр сард бүрдээгүй учраас хойшилж, өнгөрсөн сард дахин хуралдсан. Энэ хурлаар компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг багтах болон Засгийн газрын 245 дугаар тогтоолын хэрэгжилт, ТУЗ-ийг авч хэлэлцсэн юм. Компанийн гишүүнийг томилж, засаглалаа сайжруулах реформ үргэлжилж байна.

180 хоногт багтаан IPO хийнэ гэдэг амаргүй. Хэдий тийм боловч цаг хугацаатай уралдан байж “Эрдэнэс Тавантолгой”-г

дэлхийн энтэй болгосноор Засгийн газар хэлсэндээ хүрэх юм. Өмнөх засгийн газруудын үед “Тавантолгой” төсөл УИХ болон Ерөнхийлөгчийн дэмжлэг авч чадалгүй унаж байсан. Дахиад ийм байдал давтагдах вий гэсэн айдас, болгоомжлол ч энэ Засгийн газарт байв.

2017 онд ашигтай ажилласан, энэ оны эхний хагас жилийн тайлангаар 953 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан “Эрдэнэс Тавантолгой” компанийн эдийн засгийн тамир тэнхээ сайжирч, санхүүгийн үзүүлэлт нь эрс дээшиллээ. Оны эхний хагас жилд 370 гаруй тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан тус компани хамгийн хариуцлагатай цаг үед тулж ирээд байна. “Эрдэнэс Тавантолгой” компанийн 30

хувьд IPO хийснээр 1.5-6 тэрбум ам.доллар босгох боломжтой гэсэн тооцооллыг Ажлын хэсэг гаргасан. Хамгийн бодитой нь 2-3 тэрбум ам.доллар гэсэн төсөөлөл байна.

Ирэх оны эхний хагаст “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцаа олон улсын хөрөнгө оруулагчдын хүртээл болох юм. Ийм төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажил урагшилж явна. Компанийн засаглалаа сайжруулах хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” дотор өөрчлөлт, шинэчлэл бас хийгдэж байна. Компанийн удирдлагын бүтэц, орон тоог шинэчилж, удирдлагын зардлыг бууруулах, улмаар компани илүү үр ашигтай ажиллах шинэчлэл ид өрнөж байгааг дуулгая.

IPO хийх нь “Эрдэнэс Тавантолгой” компанийн олон жилийн

Долоон жилийн турш Засгийн газрын тавьсан өрийг дарахын тулд 30 гаруй сая тонн нүүрс борлуулсан “Эрдэнэс Тавантолгой” өдгөө эдийн засгийн хувьд илүү эрх чөлөөтэй болж эхэлсэн. Тиймээс энэ онд ажилтан, уурхайчдынхаа цалинг 21 хувиар нэмэгдүүлж, шөнийн нэмэгдлийг тав дахин өсгөж, ажилчдад зориулсан дэмжлэгийн санг хоёр дахин өсгөсөн. Тэрчлэн нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагтай хамтын ажиллагаагаа зузааруулж, Өмнөговь аймагтай байгуулсан гэрээний дагуу 40 гаруй тэрбум төгрөг зарцуулахаар шийдвэрлэжээ. Мөн “Эрдэнэс-Эко уурхай” хөтөлбөрийг уурхайн бүсэд хэрэгжүүлж эхэлсэн байна. Эдгээр нь уул уурхайн компаниудад нийтлэг

хүсэл байсан. Энэ хүслээ биелүүлэх боломж 2019 онд олдож байна. Харин 2020 оноос урьтаж хөрөнгө оруулагчдад хувьцаагаа санал болгож амжихгүй бол сонгууль угтсан дотоодын улс төрийн эрсдэл нэмэгдэнэ гэсэн үг.

“Эрдэнэс Тавантолгой”-г олон улсын компани болгох эрэлд ЗГ гарсан

Үүнийг ч Засгийн газар урьдчилан тооцоолж, ирэх онд зүтгүүлэхээр чармайж байна.

тулгардаг сөрөг ойлголтыг өөрчлөхөд оршдог.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар тэргүүтэй төлөөлөгчид “Тавантолгой” төслийг сонирхох хамгийн өндөр магадлалтай Австрали, Канадын хөрөнгө оруулагчидтай сая уулзаж, “Эрдэнэс Тавантолгой”-н IPO-г ярьж байгаад ирсэн. Эхлүүлсэн төслөө үр дүнд хүргэх гэж салбарын сайд нь зүтгэж байна. Өмнөх сайдуудаас ийм хичээл, зүтгэл гарч байсныг мэдэхгүй юм. Ази, Номхон далайн бүс нутаг дахь олон улсын хөрөнгө оруулагчдын хамгийн том арга хэмжээ болох “Олон улсын уул уурхай, эрдэс баялгийн чуулга уулзалт”-ын оролцогчид “Тавантолгой” төслийн талаар тодорхой ойлголттой болоод үлдсэн гэж найдья. [НҮ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2018 оны 12 дугаар сарын 16-ны өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:

Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Төвийн дулаан хангамжид холбогдох боломжгүй төрийн өмчийн 10-аас доошгүй барилгын дулааныг байгаль орчинд ээлтэй технологиор шийдвэрлэх” ажил

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:

НХААГ-18/0071

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос **“Төвийн дулаан хангамжид холбогдох боломжгүй төрийн өмчийн 10-аас доошгүй барилгын дулааныг байгаль орчинд ээлтэй технологиор шийдвэрлэх” ажлыг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй гүйцэтгэх тухай цахим тендер** ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn, хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 (тавин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **45 хоногийн** туршид хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих, түүний тоног төхөөрөмжийг хүргэх, суурилуулах ажлын нийт мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлтийг нь тооцох жилийн тоо: Сүүлийн 2 жилийн (2016, 2017 он) борлуулалтын дундаж орлого нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх.

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:

Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 оны жилийн эцсийн

баталгаажуулсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ.

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:

Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 оны аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байх.

Ижил төстэй ажилд Төвийн дулаан хангамжид холбогдох боломжгүй барилгын дулааныг байгаль орчинд ээлтэй технологиор шийдвэрлэж гүйцэтгэсэн туршлагыг тооцно.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

Тийм
Зураг төсөл боловсруулах байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд хуулбарыг ирүүлнэ.

Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог:

1.2.4. Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл түүнээс дээш эсвэл

3Т-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

1.2.5. Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл (10 кВ хүртэл)

Дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, дохиолол, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл
Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл КИП/, автоматикийн зураг төсөл болон түүнээс дээш эсвэл

3Т-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг,

цахилгаан хангамжийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд хуулбарыг ирүүлнэ.

Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог:

2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт болон түүнээс дээш, эсвэл

БА-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт болон түүнээс дээш.

2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт болон түүнээс дээш, эсвэл

БА-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт болон түүнээс дээш.

Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ.

4 000 000 /дөрвөн сая/ төгрөг

Хүчинтэй байх хугацаа: **2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийг дуустал.**

Тендерийг **2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 10 цаг 30 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг www.tender.gov.mn, www.ub-procurement.mn цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15,
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,
Утас: 75757810**

Нийгэм

“ДЦС-4” дэлбэрч мэдэх аюулаас аврагджээ

Нийслэлчүүдийн аз, эзийг сорьсон аюулын “илгээмж” илгээсээр байх уу

Г.Санжааханд
ЗГМ

Шивээ-Овоогоос “ДЦС-4”-т нийлүүлдэг нүүрсэн дотроос тэсрэх бодис илэрчээ. Тодруулбал, энэ сарын 11-ний өдөр “ДЦС-4” цахилгаан станцын нүүрсэн дотроос тэсрэх бодис илэрлээ гэх дуудлага нийслэлийн Онцгой байдлын газарт ирсэн байна. Дуудлагын дагуу НОБГ-ын Тэсрэх, дэлбэрэх бодисоос хамгаалах үндэсний аврах хүрээлэнгийн бүлэг шуурхай очиж аюулгүй болгожээ. Харин энэ мэдээллийг холбогдох албанынхан нууцлахыг оролдсон байна. “ДЦС-4” цахилгаан станцад Шивээ-Овоогоос нийлүүлсэн нүүрсэтэй хамт энэхүү аюул дагуулсан “илгээмж” ирсэн гэнэ. Яагаад тэрхүү тэсрэх дэлбэрэх бодис ийнхүү нүүрсэнд орсон болох шалтгааныг тагнуул болон цагдаагийн байгууллагаас шалгаж, тогтоохоор ажиллаж эхэлснээ мэдээллээ.

Энэ талаар НОБГ-ын дэд дарга Б.Мягмардоржоос тодруулахад “Тийм ээ! Бид дуудлагын дагуу очиж, тухайн тэсрэх дэлбэрэх бодисыг аюулгүй болгосон. Уурхайд ашигладаг тэсрэлтгүй бодис байсан. Бид тус дулааны цахилгаан станцад нийлүүлсэн бүхий л нүүрсийг нягталж шалгасан. Дахин илрээгүй” гэв. Тэрбээр өмнө нь ийм тохиолдол хэд хэдэн удаа гарч, тухай бүрт нь тус албаныхан очиж аюулгүй болгож байсан гэдгийг онцлон анхааруулж хэллээ. Гэхдээ тухайн тэсрэх бодис нь



“ДЦС-4” цахилгаан станцад Шивээ-Овоогоос нийлүүлсэн нүүрсэтэй хамт энэхүү аюул дагуулсан “илгээмж” ирсэн гэнэ.

С.Батсайхан / ЗГМ

тэслэгчгүй байсан. Тэслэгчгүй ч гэсэн зууханд ороод тэсэрч, дэлбэрээд аюул учруулах эсэхийг батлах хүн манайд байхгүй гэсэн сонин хариултыг тэрбээр мөн өгсөн.

Энэхүү хэргийн талаар “ДЦС-4” цахилгаан станцын Хяналтын албаны даргатай холбогдоход “Бид мэдээлэл өгдөг байгууллага биш. Цагдаа эсвэл онцгой байдлын газраас асуу” хэмээн утсаа таслав.

Зууханд ороод аюул учруулах, учруулахгүй эсэхийг батлах хүн манайд байхгүй

Үүний дараа “Шивээ-Овоо” ХК-ийн мэргэжилтэнтэй мөн холбогдсон боловч “Мэдээлэл өгөх боломжгүй. Дарга нараас асуу” гэсэн бөгөөд дарга нартай нь холбогдохыг хүссэн боловч татгалзсан хариу өгсөн юм.

Шивээ-Овоогийн уурхай нь үүсэн байгуулагдсан цагаасаа хойш 27 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улсын дотоодын нүүрсний хэрэглээний 28.3 хувийг нийлүүлдэг. Харин Монгол Улсын эрчим хүчний 70 хувийг үйлдвэрлэдэг “ДЦС-4” ТӨХК-ийн нүүрсний хэрэглээний 50 хувийг хангадаг. Өнөөдөр манай улсын уул

уурхайн салбарт тэсрэх механик хольцын нэгдэл, шингэн нэгдлийн эмульсийн төрлийн тэсрэх бодисыг өргөн хэрэглэдэг юм байна. Шивээ-Овоогийн нүүрснээс энэ удаад илэрсэн тэсрэх бодис ч ийм төрлийнх байсан бололтой. Мэдээллийг бэлтгэх явцад энэ төрлийн тэсрэх бодисны талаар зориуд сонирхоод үзлээ. Маш аюултай, хүчтэй дэлбэрдэг бодис юм байна. Усанд тэсвэртэй, физик тогтонги чанар сайтай, харьцангуй хямд үнэтэй байдаг аж. Түүнчлэн, бэлтгэхэд аюул осолгүй, ямар ч нөхцөлд хэрэглэх боломжтой гэнэ. Харин тэсрэлтийн шинж чанарын хувьд үзүүлэлт өндөр байдаг учир уул уурхайн үйлдвэрт нийтлэг хэрэглэдэг байна.

Хэрвээ энэ бодисыг “ДЦС-4”-ын ажилтнууд илрүүлээгүй, анзаараагүй өнгөрсөн бол зуух руу ороод юу болохыг хэн ч таашгүй. Өнгөрсөн сард “ДЦС-4”-т гэмтэл гарсны улмаас Улаанбаатар хот даяар цахилгаан тасрахад бид яаж зутарлаа. Гэрлэн дохио ажиллахгүй, замын хөдөлгөөнд асуудал гарч, иргэд өгтөн, шингэнээ яаж зохицуулахаа мэдэхгүй сандарч байлаа шүү дээ. Тиймээс эмульс гэх тэр хүчтэй тэсрэх дэлбэрэх бодис зуух руу орсон бол “ДЦС-4” цахилгаан станц яах байсан бол гэж бодохоор айдас төрөх шиг. Улаанбаатар тэр чигээрээ сүйрлийн байдал орох ч байсан юм билүү, таашгүй.

Мэргэжилтнүүдийн хэлж байгаагаар ийм явдал дахин дахин

гарч байгаа гэнэ. Тухайлбал, Багануурын уурхайгаас нүүрсээ авдаг “ДЦС-3”-т ч гэсэн ийм хэрэг гарч байжээ.

● “Дуудлагын дагуу НОБГ-ын Тэсрэх, дэлбэрэх бодисоос хамгаалах үндэсний аврах хүрээлэнгийн бүлэг шуурхай очиж аюулгүй болгожээ.

● Тэсрэлтийн шинж чанарын хувьд үзүүлэлт өндөр байдаг учир уул уурхайн үйлдвэрт нийтлэг хэрэглэдэг байна.

● “ДЦС-4”-ийн нүүрсэнд тэсрэх бодис илэрсний дараа “ДЦС-3” дээр ч түр онц байдал зарлан ажилчин, ажилтнууддаа сонор сэрэмжтэй, хянуур ажиллахыг сануулжээ.

Тодруулбал, “ДЦС-3”-т ажилладаг ажилтан нь ил асгасан нүүрсийг экскаватороор түрж байгаад тэсрэх бодис байхыг

олж харсан байна. “Иймэрхүү тэсрэх бодис нь бараан өнгөтэй, зурагтны удирдлаганы хэмжээтэй учир нүүрснээс ялгарч харагдахдаа хэцүү байдаг” хэмээн тус станцын ажилтан ярилаа. “ДЦС-4”-ийн нүүрсэнд тэсрэх бодис илэрсний дараа “ДЦС-3” дээр ч түр онц байдал зарлан ажилчин, ажилтнууддаа сонор сэрэмжтэй, хянуур ажиллахыг сануулжээ.

Ингээд цааш цаашдаа цахилгаан станцуудад нийлүүлж буй нүүрснээс энэ мэтчилэн тэсрэх бодис илэрсээр байвал яах вэ. Нүүрс нийлүүлэгч компаниуд ямар ч байсан ийм хайхрамжгүй байдлаар ажиллаад байж болохгүй ээ! Хэзээ нэгэн цагт улсынхаа гал голомт болсон цахилгаан станцуудаа дэлбэлчихээд байх байхгүйн тулд ажлын хариуцлага, хяналтаа сайжруулах цаг аль хэдийн болжээ. Эндээс нүүрсний уурхайнуудын тэсрэх бодист тавьдаг хяналт, тооцоо маш сул болох нь харагдаж байна. Хараа хяналтаа сайжруулахгүй бол нэг л өдөр бид аюулд орох нь тодорхой байна. Тэсрэх бодис илрүүлсэн ажилтныг холбогдох газрууд шагнаж урамшуулах хэрэгтэй. Ийм хэрэг дахин гаргахгүйн тулд болсон явдлыг нууж, хаах биш харин ч ил тод байх ёстойг эрхэм дарга нар ойлгох учиртай юм. Хаана, хаанаа хариуцлагатай байхгүй бол цаашид ч ийм аюул дагуулсан “илгээмж” ирсээр байх болно. Тэр хэрээр улаанбаатарчуудын амьдрал эрсдэлтэй хэвээр байна шүү дээ! [ЗГМ]

ОРОН НУТАГ

» ДУНДГОВЬ

Канадын хоршоог хөгжүүлэх сан, Монголын хоршооллын сургалт мэдээллийн төвөөс хэрэгжүүлж байгаа “Инвест Ко-оп Монгол” төслийн хүрээнд Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын малчид, иргэдэд санхүүгийн боловсрол олгох сургалтыг зохион байгууллаа. Уг төсөл нь хоршоодын бизнесийн цогц загварыг нэвтрүүлснээр жендерийн эрх тэгш байдал суурилсан өрхийн эдийн засгийн тогтвортой байдлыг бий болгоход хувь нэмрээ оруулах зорилгоор таван аймгийн 10 суманд хэрэгжиж байна.

» БУЛГАН

Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр “Хариу нэхээгүй тус” аяныг зохион байгуулсан байна. Аяны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, хэвтрийн хүмүүсийн ар гэрийнхэнд нь хэрхэн асрах, нийгэм хамт олонд нь тулгуурлан сэргээн засах чиглэлийн сургалт зохион байгуулах, сувиллагч, эмнэлгийн мэргэжилтнүүд гарын доорх материалыг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ортопедийн хэрэгсэл хийж өгөх ажлыг эрчимтэй явуулж байгаа аж.

» АРХАНГАЙ

НҮБ-ын салбар байгууллага болох Дэлхийн хүнсний хөтөлбөрөөс гамшиг, зудын эрсдлийг бууруулж, хохирул багатай даван туулах, урьдчилан сэргийлж, зохих бэлтгэлийг эртнээс хангахад нөлөөлөхүйц тоон мэдээллүүдийг малчдад мессэжээр хүргэх зорилготой “Зудын эрсдэлийн хяналтыг сайжруулж, хүн амын амьжиргааг эртнээс хамгаалахад дэмжлэг үзүүлэх” төслийн судалгааг хийж эхэллээ. Судалгаа хийхэд Дэлхийн хүнсний хөтөлбөрийн хүнсний аюулгүй байдлын үнэлгээний ажилтан Darko Petrovic тэргүүтэй мэргэжилтнүүд болон Мерси корын ажилтнууд энэ сарын 13-ны өдрөөс өнөөдрийг хүртэл ажиллаж юм.

» ЗАВХАН

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбооноос 25 жилийн ойгоо угтаж бизнес эрхлэгчдэд зориулсан нүүдлийн номын сан энэ сарын 14-ний өдрөөс ажиллаж эхэлсэн байна. Тус холбооны удирдах зөвлөлийн 30 гаруй эмэгтэй уран зохиолын болон бизнесийн амжилтын үүх түүх, түүхийн, шинжлэх ухааны, гоо сайхны холбогдолтой 150 гаруй ном цуглуулжээ. Эдгээр номыг Улиастай сумын томоохон дөрвөн худалдааны төвд байрлуулсан бизнес эрхлэгчдэдээ номын сангийн үйлчилгээг үзүүлж эхэлжээ. Тус төвд бизнес эрхлэгч буй худалдаачид өөрийн цахим иргэний үнэмлэхээрээ дамжуулан номыг хоноогоор болон өдрөөр түрээслэн авч унших боломжтой юм байна.

» ХОВД

Аймаг, орон нутгийн удирдлагын зүгээс орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад тавих хяналт сул учир 2016-2017 онд 17.8-18.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Эдгээр байгууллагад 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт найман тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө байршсан бөгөөд 1.2 тэрбум төгрөгийн өр төлбөр үүссэн байна. Иймд орон нутгийн өмчийн ашиглалт, менежментийг сайжруулах талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймаг, орон нутгийн удирдлагад АТГ-ын ажлын хэсгээс мэдэгдсэн байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Агаар бохирдуулсан иргэнийг 50 мянгаас нэг сая төгрөгөөр торгоно



Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас өчигдөр агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд хийж гүйцэтгэсэн хяналт шалгалтын талаар мэдээлэл хийлээ. Агаарын чанарыг сайжруулах бүсэд харьяалагдах 138 хороодыг хариуцсан 152 улсын ахлах байцаагчийг НМХГ-ын даргын тушаалаар томилж, агаар бохирдуулагч эх үүсвэрүүдэд хяналт шалгалт хийсэн байна. Энэ хүрээнд машины дугуй, хог,

хуванцар шатаах, тортог ихтэй тээврийн хэрэгслээр авто замын хөдөлгөөнд оролцох зэрэг хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулан агаар бохирдуулж буй зөрчлийн талаарх мэдээллийг НМХГ-ын Шуурхай албаны 70128012 дугаарын утсаар мэдээлэл өгөхийг уриалав. Зөрчлийн тухай хуулиар агаар бохирдуулж буй хүнийг 50 мянгаас нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг 500 мянгаас 10 сая хүртэл төгрөгөөр торгох юм байна. [ЗГМ]

ҮЙЛЧИЛГЭЭ

Эрсдэлт нөхцөлд байгаа 7-9 мянган хүүхдийг даатгалд хамруулна

Ерөнхий сайд У.Хүрэлсүх өчигдөр “Өнөр бүл”, “Эрдэм” асрамж халамжийн хүүхдүүдтэй уулзаж, “Хүүхэд хамгааллын даатгал”-ын багламж гардууллаа. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, “Номин даатгал” ХХК-тай хамтран “Хүүхэд хамгааллын даатгал”-ын бүтээгдэхүүн үйлчилгээг шинээр бий болгож, эхний ээлжинд эрсдэлт нөхцөлд амьдарч буй 7000-9000 хүүхдийг төрөөс даатгахад болжээ. Улс хүүхдийн эрхийг хамгаалах, гэмт хэргийн

хохирогч болох, бага насны хүүхдийн эрх зөрчигдөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль эрхзүйн орчноо сайжруулж байгаа хэдий ч бага насны хүүхдүүд эрсдэлт нөхцөлд орох тохиолдол гарсаар байгаа юм. Тиймээс “Хүүхэд хамгааллын даатгал”-ын үйлчилгээнд хамрагдсанаар гэнэтийн ослын болон үл хайхрах, хүчирхийлэлд өртөх зэрэг эрсдэлт тохиолдсон үед нөхөн сэргээх үйлчилгээний зардлыг даатгалын байгууллага нөхөн төлөх боломж нээгдэх юм. [ЗГМ]

БОЛОВСРОЛ

Бямба гарагт цэцэрлэг, сургуулиуд хичээллэнэ

Энэ сарын 17-нд буюу бямба гарагт төрийн өмчийн бүх цэцэрлэг, сургуулиуд хичээллэнэ. Өнгөрсөн долоо хоногийн пүрвэ гарагт “Монгол бахархлын өдөр” тохиосон. Энэ өдөр бүх нийтээр амардаг бөгөөд Засгийн газрын хуралдаанаар баасан гарагт мөн амрах шийдвэр гаргасан билээ. Ингэснээр арваннэгдүгээр

сарын 9-ний өдрийн ажлыг дараа долоо хоногийн бямба гарагт шилжүүлсэн юм. Тиймээс өнгөрсөн баасан гарагийн ажил болон хичээлийг энэ бямба гарагт нөхөх бөгөөд Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яамнаас төрийн өмчийн бүх цэцэрлэг, сургууль тус өдөр хичээллэнэ хэмээн мэдэгдсэн байна. [ЗГМ]

[ЗГМ СӨНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга Эрдэнэбаатарын ДОЛГИОН
Ерөнхий эрхлэгч Баатарын ДУЛАМХОРЛОО
Зөвлөх Шатарбалын ДАВААДОРЖ
Орлогч эрхлэгч Лхагважавын СУГАРМАА Утас: 99903584
РЕДАКЦ
Улс төр, нийгэм, эрэн сурвалжаах мэдээллийн алба Эдитор Б.Энжаргал Утас: 99901621
Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба Эдитор Г.Баарсайхан Утас: 99903574
Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
ЗАР СУРТАЛЧИЛГАА
Утас: 99903581 99903578 99907843
ХАЯГ
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 хороо, Энхтайвны өргөн чөлөө, “Блю Скай тауэр” 407 тоот Улсын бүртгэлийн дугаар: 1024 Утас: 70103131, Факс: 7010606
ЦАХИМ ХУВИЛБАР
zgm.mn ubinfo.mn
Дугаарын удирдагч Г.Баарсайхан

Эрүүл мэнд

Дааврын бэлдмэлтэй эм таргалуулдаг гэдэг нь нотлогдоогүй

З.Гэрэл
ЗГМ

Саяхан Охайогийн их сургуулийн профессорууд нэгэн сонирхолтой дүгнэлт гаргалаа. Эмийн гаж нөлөөг судалсан 49 судалгааны үр дүнг тоймлож, эмийн хэрэглээ ялангуяа, жирэмслэлтээс сэргийлэх эм уувалжин нэмэгддэг гэсэн ойлголт буруу болохыг тогтоожээ. Харин ийм эмнүүд биеийн галбир өөрчилдөг гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Судалгааны авторууд “Жин нэмсэн шалтгаанаа эмнээс хайдаг эмэгтэйчүүд олон. Харамсалтай нь, үүнийг эрдэмтэд хэдэн арван жил судалж буй ч туйлын үнэн гээд баталчих нотолгоо байхгүй байна” гэжээ.

Эмэгтэйчүүдийн хэрэглэдэг эмийн дийлэнх нь нийлэг аргаар гаргаж авсан эстриол, прогесторон хэмээх дааврын агууламж ихтэй. Тиймээс судлаачид ийм найрлагатай



ВВМ©

Эм таргалуулдаггүй, харин галбир өөрчилдөг

эмийн гаж нөлөөнд хийсэн судалгаанууд дээр илүү төвлөрсөн байна. Лабораторид гаргаж авсан эстриол, прогесторон нь байгалийнхаас 6-10 дахин их хүчтэй үйлчилгээтэй бөгөөд эмэгтэйд шинжийг илүү тодотгодог эдгээр дааврыг хүлээж авдаг маш идэвхтэй голомтууд хүний биед байдаг аж. Энэ нь биеийн галбир өөрчлөгдөхөд нөлөөлдөг байна. Үүнийг батлахын тулд профессорын баг булчингийн хөгжил, өөхөн давхарга, эмийн түвшинд дээрх төрлийн даавар бүхий эм хэрхэн үйлчилдгийг тайлбарлажээ.

БУЛЧИНГИЙН ХӨГЖИЛ СААРУУЛДАГ

АНУ-ын Техас мужийн Хөдөө аж ахуй, механикийн коллежийн физиологич Стивен Риечмэн 2009 онд эмийн нэгэн хачирхалтай нөлөөг тун санамсаргүй байдлаар илрүүлжээ. Тухайн үед тэрбээр дасгал хөдөлгөөнөөр булчингаа хөгжүүлэхэд хүний төрөлх чадвар буюу ген хэрхэн нөлөөлдийг судлахаар эрэгтэй, эмэгтэй хүмүүсээс нийлсэн баг бүрдүүлж, 10 долоо хоногийн турш хөнгөн дасгалаас эхлээд хүндийг өргөлт зэрэг хүнд дасгалуудаар хичээллүүлжээ.

Энэ хугацаанд оролцогч нэг бүрийн амьдралын хэв маягийг судалж, мэдээлэл цуглуулж, тэгснээрээ булчин хөгжүүлэхэд хүмүүсийн ген, бүр ууж байгаа эм нь хэрхэн нөлөөлж буйг ч тогтоох боломж олдв. Туршилтаар дааврын бэлдмэлтэй эм хэрэглэдэг эмэгтэйчүүдийн булчингийн хөгжил бусад эмэгтэйчүүдээс 40 хувиар сул байжээ. Эрэгтэй хүн бол байгалиасаа булчингийн хөгжлөөр эсрэг хүйстнээсээ илүү. Хэвийн жинтэй эрэгтэй хүн дунджаар 33 кг булчинтай байдаг бол

эмэгтэй хүнийх 21 кг байдаг аж. Эрэгтэй хүний жин их, өндөр байдаг нь ч үүнтэй зарим талаар холбоотой. Гэхдээ биеийн бүх жинд харьцуулж үзвэл эрэгтэйчүүдийн биеийн 38, эмэгтэйчүүдийн 31 хувийг булчин эзэлдэг. Булчингийн хөгжилд чухал үүрэгтэй анаболик стероид нь хүний бүх л биеэр ясанд хүртэл үйлчилж, дархлааг нь дэмждэг аж. Харин эмэгтэй хүн анаболик даавар ялгаруулдаг хэдий ч эм хэрэглэж буй нөхцөлд цусан дахь даавар эрс багасдагийг физиологичид илрүүлсэн байна.

Эстриол даавартай ЭМ ЭМЭГТЭЙ-ЧҮҮДИЙН ГАЛБИРЫГ ЛИЙР ХЭЛБЭРТЭЙ БОЛГОДОГ

Бас нэг хачирхалтай баримт бол нийлэг прогесторон дааврын агуулгатай эм хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн булчин огт хөгжөөгүй байжээ. Энэ талаар Риечмэн “Булчин хөгжихгүй байгаа шалтгаан бол прогесторон. Булчин илүү томорч, хөгжих гэсэн дохиог нь энэхүү даавар хаадаг байж болзошгүй” гэжээ.

ДААВАРТ ИДЭВХТЭЙ ӨӨХӨН ДАВХАРГА

Эм бэлдмэл мөн биеийн өөх их хуримтлагдсан хэсэгт илүү нөлөөлдөг байж мэдэх аж. Бэлгийн бойжилтын үед эстриол, прогесторон нь эмэгтэй хүний ташааг илүү өргөн болгож, хөх томруулах зэргээр эмэгтэйд шинжийг нь тодотгоход чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ингэснээр

өөх тосыг биеэр өргөн хүрээнд тархах боломж бий болгодог байна. Эмэгтэй хүний хөх, ташаа, гуя орчмын арьсан доор агуулагддаг өөх нь эстриол даавар их хэмжээгээр хүлээж авдаг найрлагатай аж. Өөрөөр хэлбэл, онолын хувьд ч эмэгтэй хүний дааврын тэнцвэр өөрчлөгдсөнөөр өөх тос биеийн аль хэсэгт нь хуримтлагдахыг мэдэх хэцүү биш. Үүнийг баталсан судалгаа ч бий. Тухайлбал, эстриол даавар их агуулсан эм хэрэглэдэг эмэгтэйчүүдийн галбир лийр хэлбэртэй байдаг. Мөн таргалалтад төдий л чухал нөлөө үзүүлдэггүй арьсан доорх өөхөн давхарга ихтэй байдаг байна.

ЭСИЙГ ХАВАГНУУЛДАГ

Эм хэрэглэдэг эмэгтэйчүүдийн хамгийн том айдас нь хавагнах юм. Энэ таагүй хөөнгө мэдрэмж бол организмын бодисын солилцоог тэтгэдэг хүний бие дэх усанд эстриол нөлөөлж буй хэрэг юм. Бодисын солилцоонд оролцож буй ус эстриол ихтэй байвал бөөрнөөс ялгардаг уурагт нөлөөлж биеийн шингэн ердийнхөөс ихэсдэг байна. Улмаар ийм найрлагатай ус өөхний эсэд нэвчиж, хавагнуулдаг бөгөөд үүнд хамгийн өртөмтгий хэсэг эмэгтэйчүүдийн хөх, гуя, ташаа юм. Мөн эм төдий л хэрэглэдэггүй эмэгтэйчүүдийн биед ч бага хэмжээгээр нөлөөлдөг аж. Гэхдээ сарын мөчлөг ирэхээс яг өмнөх долоо хоногт ийм өөрчлөлт явагддаг байна.

Даавар их агуулдаг эм бэлдмэл биеийн унаган төрхийг дээрх замаар өөрчилдөг бөгөөд бидний дийлэнх нь үүнийг таргалалттай андуурдаг байна. Эрэмтдийн онцолж буйгаар хүн насанд хүрснээсээ хойш бүх л амьдралынхаа турш жилд дунджаар хагас кг-аар жин нэмдэг. Энэ нь эмэгтэйчүүдийн

хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх арга хэмжээ авч эхэлдэг үетэй давхцадаг аж. Тиймээс жин нэмж буй шалтгааныг

буруу хооллолт, амьдралын буруу зуршлаас илүүтэй эмэнд тохих хандлагатай байдаг байна. [ЗГМ]

НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ЗАР

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 496 тоот тогтоолын дагуу “Хьюндай старекс” маркын автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэв.

1. Дуудлагаар худалдах хөрөнгийн танилцуулга:

Харилцаа холбооны зохицуулах хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй “Хьюндай старекс” маркын автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдана.

Товч танилцуулга: Улсын дугаар: УНА 01-05, Аралын дугаар: KMJWAN7JP8U039178, Үйлдвэрлэсэн он 2008, Монгол улсад ашиглаж эхэлсэн он 2008, Өнгө: мөнгөлөг. Хөдөлгүүрийн багтаамж: 2497 cc, дизель

2. Дуудлагын худалдааны ерөнхий мэдээлэл

Дуудлагын худалдаа болох хугацаа	2018 оны 12 дугаар сарын 17-ны Даваа гарагт 11.00 цагт
Дуудлагын худалдаа болох газар	Улаанбаатар-14201 Сүхбаатарын гудамж-13 Бага тойруу 6-р хороо Метро бизнес төв А корпус 12 давхар хурлын заал. Харилцаа холбооны зохицуулах хороо
Худалдах доод үнэ	3,000,000.00 (гурван сая) төгрөг
Дуудлагын худалдаанд тавих дэнчингийн хэмжээ	Худалдах доод үнийн 25 хувь буюу 750,000 (долоон зуун тавин мянга) төгрөг
Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөл	Худалдан авагч нь дуудлагын худалдаагаар авсан эд хөрөнгийн үнийг 14 хоногийн дотор төлнө.
Дэнчин байршуулах данс	Хүлээн авагч байгууллага: Харилцаа холбооны зохицуулах хороо Дансны дугаар: 1102626829 Голомт банк Дансны нэр: Харицаа холбооны зохицуулах хороо

3. Дуудлагын худалдаанд хүсэлт ирүүлэх:

Дуудлагын худалдаанд оролцох хүсэлтийг 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11:00 цаг хүртэл Улаанбаатар-14201 Сүхбаатарын гудамж-13 Бага тойруу 6-р хороо Метро бизнес төв А корпус 5 давхарт хүлээн авна. Хугацаа хоцорсон хүсэлтийг хүлээн авах боломжгүйг анхаарна уу.

Дуудлагын худалдаанд оролцох хүсэлт нь зөв, цэвэр бөглөсөн худалдаанд оролцох хүсэлтийн маягт, дэнчин төлснийг нотлох банкны тамгатай баримтын эх хувь, иргэний үнэмлэх /хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээ/-ийн хуулбар зэрэг баримтаас бүрдэнэ.

4. Мэдээлэл авах:

Дуудлагаар худалдах хөрөнгийн өмч эзэмшигч Харилцаа холбооны зохицуулах хорооны харьяа Сонгино хайрхан дүүргийн 1-р хороо, Орбит 18170, Найрамдлын зам 43 тоот хаягт байрлах “Радио долгин хяналтын төв”-д очиж үзэх боломжтой бөгөөд дуудлага худалдааны журам, бүртгэх хугацаа, хөрөнгийн талаарх мэдээллийг доорх хаяг, утасаар авч болно.

Хаяг: Улаанбаатар-14201 Сүхбаатарын гудамж-13 Бага тойруу 6-р хороо Метро бизнес төв А корпус 5 давхар Утасны дугаар: 304258, 99081514

ҮЙЛЧИЛГЭЭ

Эгэм, далны гэмтлийн мэс заслыг дэвшилтэт аргаар хийдэг боллоо

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн эмч мэргэжилтнүүд орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан “Эгэм далны холбоосны урагдал, гэмтлийг зангуут түгжээ ашиглан сэргээх” мэс заслын арга нэвтрүүлэн ажиллаж

эхэллээ.

Өмнө нь мэс заслын уг эмчилгээг уламжлалт ил аргаар буюу дэгээ хэлбэрийн ялтсаар эгэм далны холбоосыг сэргээдэг байжээ. Гэвч мэс заслын дараа мөр өвдөх, мөрний хөдөлгөөн хязгаарлагдах, дэгээ ялтас

мултрах, шарх үрэвсэх гэх мэт гомдол, санал их ирдэг байв.

Харин нэг удаагийн зангуут түгжээ товчтой материал ашиглан эгэм далны холбоосыг хагас ил аргаар сэргээх мэс засал нь эмчилгээний өндөр үр дүнтэй аж. [ЗГМ]

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР



- 09:00** “Хүсэл” ОАК төгсгөлийн анги
- 10:30** Эх өв
- 15:20** “Соёл-Эрдэнэ” хөтөлбөр
- 17:15** Монголын түүх “Монголын эзэнт гүрэн дэлхий дахинд”
- 20:00** “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөр
- 23:00** “Гэрэлтэй цонх” үдшийн хөтөлбөр

Bloomberg TV Mongolia

- 07:00** “Суутнуудын намтар” нэвтрүүлэг
- 11:00** “#MadeInMongolia” нэвтрүүлэг
- 14:00** “Дэвид Рубенштэйний шоу” нэвтрүүлэг
- 18:00** “Бизнесийн төв цэг” давталт
- 22:00** “Суутнуудын намтар” нэвтрүүлэг
- 23:00** “Мөнгөний урсгал” давталт

БОЛОВСРОЛ HD

- 08:35** “Монголчууд ХХ зууны эхэнд” нэвтрүүлэг
- 10:10** “Миний нөхөр У Жаг Ду” ОАК 11-р анги
- 14:10** “Аяыг таа” шоу нэвтрүүлэг
- 16:10** “Бяцхан оцон шувуу Пороро” хүүхэлдэйн кино 2-43-50
- 20:30** “Хүрээлэн” амьд ертөнц нэвтрүүлэг
- 23:15** “Көсем” ОАК 2.59, 60-р анги



- 10:00** “Хүүхдийн ертөнц” хүүхэлдэйн кино 4-р анги
- 12:30** “Гранд зочид буудал” Испанийн ОАК 44-р анги
- 16:00** “Он цагийн учрал” СОАК 12-р анги
- 19:00** Оргил цаг мэдээллийн хөтөлбөр
- 21:30** “Хавай 5-0” /season-8/ 10-р анги
- 01:30** “Чимээгүй номын сан” 1-р хэсэг

ЗУРХАЙ



Билгийн тооллын 9 Өвлийн тэргүүн харагчин гахай сарын нэг цагаан мэнгэтэй хар хулгана өдөр. **Үс засуулбал:** Өвчин өчүүхэн ирнэ. **Наран ургах, шингэх:** 07.59-17.17 **Барилдлага:** Шид **Шүтэн барилдлага:** Сэрэхүй **Суудал:** Гал

Аргын тооллын арваннэгдүгээр сарын 16, Сугар гараг. Билгийн тооллын 9, чөдөр одтой, хар хулгана өдөр. Өдрийн наран 07.59 цагт мандан, 17.17 цагт жаргана. Тухайн өдөр луу, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнэс эхлэх, зэрэг дэвших, угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улааны үйл, төлөг тавих, морь уралдуулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой.

ОНЦЛОХ ҮЗВЭР

Асрагч аавын хөгжилтэй түүх



Чинээлэг гэрийн эзэгтэй Сарнай асрагч зуучлалын компани дээр ирж ажилд орохоор ирсэн хүмүүсээс ярилцлага авна. Тэрээр олон бүсгүйчүүдтэй ярилцсан ч цорын ганц эрэгтэй болох Гочоог ажилд авахаар сонгоно. Гочоо асрагч хийхээр айлд очиход эрх дураараа өссөн, дөнгөж арван жилээ төгсөөд буй Индра, дэггүй нь дэндсэн бага ангийн сурагч Анар нар угтаж авна. Тэдний хөгжилтэй, баяр хөөр дүүрэн, адармаатай, эмгэнэлт түүхийг “Асрагч аав” киноноос та бүхэн хүлээн авч үзээрэй. Д.Хүрэлхүү, Г.Нарансолонго нарын тоглосон энэхүү кино арваннэгдүгээр сарын 2-ноос эхлэн “Өргөө” кино театрын дэлгэцнээ гарч байна. [ЗГМ]



Sara's fashion show
Хаана: One event hall
Хэзээ: 2018.11.16-ны 20.00 цагаас
Тасалбарын үнэ: ₮100 мянга




“Одын өвчин” жүжиг
Хаана: УДЭТ
Хэзээ: 2018.11.16-ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮10-50 мянга



“Soprano” тоглолт
Хэзээ: 2018.11.16-ны 19.00 цагт
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮30-50 мянга

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:

- Хатан гэгддэг гол
- Явсан зам
- "Voice Mongolia" тэмцээний ялагч
- Д.Сүхбаатар жанжны гэргий, төр нийгмийн зүтгэлтэн
- Нигүүлсэнгүй сэтгэл
- Өвлийн адаг сарын битүүний үдэш айлуудаар зочилдог гэх бурхан
- Уламжлалт эмчилгээний эм бэлдмэл

18. Зөгийнөөс гардаг ашиг шим

- ХӨНДЛӨНГӨӨР:**
- Хайрга залгиж хоолоо шингээдэг шувуу
 - Монголчууд эртнээс суурай цай дотор нь хийж нүүдүүрээр буталдаг сав
 - Хонь, ямааг зандах үг
 - Амтат жимс
 - Шүд бүхий урт ястай эрхтэн

- Согтууруулах ундаа
- Америкийн сансар судлалын төв (товчилсон нэр)
- Москва-Улаанбаатар-Бээжин чиглэлийн галт тэрэгний нэр

- арьс, махны завсар үрждэг өт хорхой
- Ойн бяцхан мэрэгч амьтан
- Латви улсын нийслэл
- Монголд үүрэг гүйцэтгэдэг Японы алдартай ачааны машин, автобус

ТАШУУГААР:

- Мал гөрөөсний нурууны

Өмнөх дугаарын хариу / 11.15

С	А	Х		С	Э	У			
У	У	Р	Г	А	Е	Э	В	Э	Н
М	А	А	А	Р	Э	А			
О	Т	Г	О	Н	Б	А	Р	Г	А
А		Й		А		Р		А	
Х	Э	Р	М	Э	Н	Ц	А	В	

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

XI.16 -9° / -20° 6 м/с / 5 м/с Багавтар үүлтэй	XI.17 -6° / -17° 6 м/с / 5 м/с Үүлшинэ	XI.18 -8° / -14° 8 м/с / 7 м/с Ялимгүй цастай	XI.19 -9° / -19° 6 м/с / 5 м/с Багавтар үүлтэй	XI.20 -8° / -17° 7 м/с / 5 м/с Үүлшинэ
--	--	---	--	--




ФОТО АГШИН



Тусгал

Б.Хасуй / ЗГМ



Жизель балет
Хэзээ: 2018.11.17-ны 17.00 цагт
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга



CITY SWING jazz night
Хэзээ: 2018.11.23-ны 19.00 цагт
Хаана: Улсын филармони
Тасалбарын үнэ: ₮25 мянга



“Чи минь байгаа болохоор” тоглолт
Хэзээ: 2018.11.23-24-ний 19.00 цагт
Хаана: UB Palace
Тасалбарын үнэ: ₮30-50 мянга

ЗГМ: СҮДОКУ

				9	8	5		
			6	7				
4	9	1						
		3		8				
			7	2				
9				5	3		1	
	2						3	9
	1	5					7	2
	7			6				

6	8	1	2	9	7	4	5	3
7	5	3	6	8	4	2	1	9
2	9	4	1	5	3	8	7	6
9	4	5	7	6	1	3	8	2
8	3	6	4	2	5	1	9	7
1	7	2	8	3	9	5	6	4
4	2	7	5	1	6	9	3	8
5	6	9	3	4	8	7	2	1
3	1	8	9	7	2	6	4	5



ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

ЭРЭЭН-УБ	18.00	11.15
УБ-ХӨХ ХОТ	20.00	20.49
ХӨХ ХОТ-УБ	22.50	11.15
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-СҮХБААТАР	21.15	05.12
СҮХБААТАР-УБ	20.55	05.03
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48
УБ-ЗАМЫН-ҮҮД	17.20	07.05
ЗАМЫН-ҮҮД-УБ	17.35	08.55



НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-БЭЭЖИН	17.15	19.30
БЭЭЖИН-УБ	20.30	23.00
УБ-ХОНКОНГ	07.50	12.25
ХОНКОНГ-УБ	13.25	18.05
УБ-СӨҮЛ	07.45	12.05
СӨҮЛ-УБ	13.20	16.05
УБ-ТОКИО	08.55	14.30
ТОКИО-УБ	15.30	20.25
УБ-ХӨХ ХОТ	10.30	12.00
ХӨХ ХОТ-УБ	13.00	14.40
УБ-ЭРХҮҮ	06.20	07.20
ЭРХҮҮ-УБ	08.20	09.20

ZGM DAILY

President puts veto on 2019 State Budget

The letter highlights several issues, including high budget deficit.

GDP reaches MNT 12.8 trillion in September

Key driver in the growth was the service sector, which grew by MNT 349.2 billion.

President receives Wealth Creators Support Association

The association proposes revision to current bill on SMEs, which identifies micro businesses.

Air Pollution Reduction Department holds press conference

Emissions of 58 percent buses in public transports exceeded the permissible levels.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

Food Security Monitoring Consultant at UN World Food Programme Darko Petrovic and representatives of Merzi Corps are working in Arkhangai aimag to conduct a study on providing support in improvement of dzud risk management and early assessment of people's livelihoods. The project is aimed at providing the herders with information that can assist in reducing the risk and prevent from dzud and carrying out early assessment.

ECONOMY

Trade turnover totals USD 10.8 billion in October with exports account for USD 5.9 billion and imports - USD 4.9 billion.

As of October, average price of cattle hide was the lowest in Khovd aimag at MNT 5,000 per meter, while the highest was in Selenge aimag at MNT 20,000.

Top 20 Index falls 1.07 percent, to 20,143.71 points. MSE A Index drops 1.16 percent, to 9,691.93 points. MSE B Index increases 0.3 percent, to 8,503.96 points. Market cap stands at MNT 2.38 trillion.

SOCIETY

Grand Theater of National Arts announces its winter performance schedule. The theater will open its winter performances with a concert Naran Tamgatai Talyn Mongol (Steppe Mongolia with Sun Seal) on November 28, 29 and 30.

President vetoes 2019 State Budget

2019 Monetary Policy Guidelines approved, target level kept at 8 percent


Tugsbilig.B
@tugsbiligZGM

President of Mongolia Battulga Khaltmaa put a veto on the Law on 2019 State Budget and the accompanying legislation and parliamentary resolutions. President Battulga handed over an official letter to Parliament Speaker Enkhbold Miyegombo, requesting action in accordance with the corresponding laws and regulations yesterday.

The veto reads, "I have reviewed the Law on 2019 State Budget, which was adopted by the Parliament on November 2 and forwarded to the President's Office on November 12.

I have no choice, but to veto the 2019 budget and remind the Parliament of the necessity to look back on its budget policy, adopt a tighter and more efficient budget that upholds the national interest and discipline, and fix the following issues that violate the law and contradict the national development policy and vision."

The letter highlights several issues in the 2019 State Budget Law, including high budget deficit which is MNT 1.9 trillion



president.mn®

or 5.4 percent of GDP. "MP's money" amounting to MNT 8 billion and budget allocation for the construction of facilities without blueprint, and estimation of the mining revenue at MNT 3 trillion, which was concluded as unattainable by the National Audit Office. Furthermore, the President points out that the 2019 State Budget Law creates conditions for abrupt increase of public debt and that the projection of MNT 11.5 trillion budget expenditure is not compatible with the objective to maintain inflation within eight percent next year. In addition, President Battulga stresses that the lawmakers must create

conditions for small businesses that are truly considered SMEs to be able to obtain loans with 3 percent annual interest from the SME Development Fund starting from January 1, 2019.

GOVERNMENT PLANS TO REDUCE INFLATION TO 6 PERCENT IN MID-TERM

Later on, the Parliament, at its plenary session, approved the 2019 Monetary Policy Guidelines. Officials highlighted that the monetary policy will focus on overall financial and economic stability, as well as creating legal regulations for consumer protection next year.

According to the guidelines, the Bank of Mongolia (BoM) will implement policies to stabilize inflation measured by consumer price index at eight percent for the next two years and reduce it to six percent in the mid-term. "Since external demand and commodity price fluctuations remain high, the monetary policy will be directed towards overall employment in all sectors and preserve inflation within expectation," said a spokesperson of the Parliament. BoM also viewed that the inflation can be stabilized under the target level in 2018-2019.

In order to reduce the impact of foreign economies, improve the

country's economic vulnerability, maintaining balance of external sectors and creating financial sources to repay foreign debts foreign exchange (FX) reserves must be raised, says the BoM and informed that the guidelines include objectives to increase FX reserves and necessary coordination between government bodies.

The BoM views that the financial market infrastructure and institutes must be strengthened to improve the effects of monetary policy and financial stability. Therefore, the guidelines included several objectives on protecting the rights of financial consumers, creating legal environment, adopting common internationally-approved practices of stable financing, identifying the standards of technology-based financial products and services, as well as ensuring the safety and reliability of customer information.



The monetary policy guidelines also reflected several objectives on improving assets of commercial banks and transparency of the BoM.

MP Javkhlan Bold addressed, "The monetary policy does not have to align with the budget. But the two policies should mutually support their respective objectives. Both revenue and expenditure of the 2019 budget are vastly expanded. The balance of payment and current account are expected to be under a deficit. Accordingly, there is a high possibility that inflation will rise next year; thus, we expect more tight monetary policy." [ZGM]

STATISTICS

NSO releases October statistics: Economy grows 6.4 percent yoy as of September

	2015/ I-X	2016/ I-X	2017/ I-X	2018/ I-X
Equilibrated revenue	4569.3	4494.4	5835.4	7519.5
Expenditure	5484.6	6814.7	6504.6	7177.6
Equilibrated balance	-915.3	-2320.4	-669.2	341.9



Total equilibrated revenue and grants of the General Government Budget reached MNT 8.3 trillion and total expenditure and net lending amounted to MNT 7.2 trillion in the first 10 months of this year. The equilibrated balance, which was MNT 669.2 billion in deficit in Octo-

ber 2017, totaled MNT 341.9 billion in surplus in the same month of this year. The General Government revenue comprised of 81.3 percent of tax revenue, 9.7 percent of non-tax revenue, 6.8 percent of the future heritage fund and 2.3 percent of stabilization fund.

As of September 2018, the GDP reached MNT 12.8 trillion, increasing 6.4 percent year over year. Key driver in the growth was the service sector, which grew by MNT 349.2 billion or 7 percent (wholesale and retail trade sector by MNT 88.5 billion

or 6.5 percent) and net taxes on products by MNT 305.5 billion or 22.9 percent.

The seasonally adjusted GDP increased by 0.8 percent in the third quarter compared to the previous quarter.

In October, the nationwide consumer price index (CPI) increased by 0.1 percent from the previous month, by 5.6 percent from the end of the previous year and by 6.3 percent from the same period of last year.

Key impacts include increase in

prices of food and non-alcoholic beverages group by 5.4 percent, alcoholic beverages and tobacco group by 8.1 percent, transport by 8.3 percent, housing, water, electricity and fuels group by 11.0 percent and health by 12.7 percent. [ZGM]

PRIVATE SECTOR

Private sector representatives criticize current bill on SME

Upon the request of the Wealth Creators Support Association, President of Mongolia Battulga Khaltmaa received their representatives yesterday.

At the meeting, head of the Association said that the draft revision to the Law on Small and Medium-sized Enterprise (SME), which has been submitted to the Parliament, contains very few provisions that are designed to protect and promote the interests of SMEs. He also thanked President Battulga for giving them the opportunity to meet and express their opinion on the bill.

Founded in 2015, the Association now has active branches in 21 provinces and seven districts of the capital city with over 100 thousand members.

The participants of the meetings, small business owners from more

than 10 provinces and seven districts, handed over a draft proposal which they believe is required to find reflection in the bill on SMEs to President Battulga.

Key highlight of the proposed bill of the association was the term "micro business". Criticizing the current bill, the association included an article that identifies micro businesses as entities with 1-9 workers and annual sales revenue of MNT 250 million. The representatives explained that the current bill will allow entities with annual revenue of MNT 50-60 billion and over 200 employees to be categorized as an SME and receive loans from SME Development Fund, as the bill does not consider the number of workers in categorizing them. Therefore, the association suggested to consider both the number of workers and revenue. [ZGM]

AIR POLLUTION

Officials present inspection reports on emission

Air Pollution Reduction Department (APRD) of the Municipality of Ulaanbaatar held a press conference and presented inspection process yesterday.

Within the frame of the national program on reducing air pollution, the APRD is organizing inspections on identifying emissions of diesel-powered vehicles in cooperation with the National Road Transport Center and Traffic Police Authority.

The inspection report shows that smoke emissions of over 136 (58 percent) buses of 17 public transportation entities exceeded the permissible levels. APRD informed that these companies were ordered to eliminate deficiencies and certain entities are being fined.

Furthermore, the APRD held inspections on public toilets that are not connected to the centralized network. "The inspection team demolished 21 unsanitary public toilets that did not meet health re-



Batsaikhan.S / ZGM ©

quirements located in front of eight service centers of six districts and replaced them with qualifying toilets. Common violations of the inspection were overloading of soil, which

resulted in soil and water pollutions. APRD spokesperson also noted that the use of trash, tire, plastics and used oil as fuels is another major air pollution factor as the process emits

dioxin and furan toxic components, pollution soil with soot and ash. Thus, the APRD called for not burning these items and avoid driving vehicles with high soot level. [ZGM]

Амьдралын хэв маяг

Энэ өвөл үслэг хүрэм зонхилно

*Моод эргэж,
1990-ээд оны
хувцас эргэн ирлээ*

С.Энэрэл
ЗГМ

Өвөлдөө тэсгим хүйтэн уур амьсгалтай монголчууд бидний хувьд хэрхэн дулаан атлаа дэгжин харагдах вэ гэдэг нь “толгой ажиллуулах” асуудлын нэг. Гэхдээ ирэх өвөл өмнөх жилийг бодвол хот суурин газраар дулаан байх төлөвтэй байгаа талаар холбогдох мэргэжилтнүүд мэдээлж буй. Манай орны иргэдийн хувьд баруунд моодонд орсон хувцсыг өмсөх сонирхолтой. Мэдээж хүн бүхэн өөрийн дотоод ертөнцийг илтгэсэн хувцас өмсөх хүсэлтэй байдаг. Энэ хүсэлдээ нийцсэн сонголтыг хийхийн тулд тухайн жилдээ трэнд болж буй загварын чиг хандлагыг судлах хэрэгтэй. Тэгвэл энэ өвөл ямар загварын хувцас трэнд болж буйг хамтдаа сонирхъя.



ӨВЛИЙН ЗАГВАРЫН ЧИГ ХАНДЛАГА ДЭЛХИЙД

Загварын ертөнцөд өөрийн гэсэн байр сууриа тогтоосон Нью-Йорк, Парис зэрэг томоохон хотод энэ жил үслэг хүрмийг үндсэн загвараараа тодорхойлоод байна. Байгалийн зэрлэг ан амьтдыг санагдуулам хиймэл болон жинхэнэ арьсан хүрэм бусдаас ялгарахыг хүсдэг хүмүүст илүү тохиромжтой. Гаднын ихэнх улсад жинхэнэ амьтны арьсан хүрмийг хориглодог тул хиймэл үсээр хийсэн хувцас сонгох нь элбэг.

Загварын чиг хандлага эргэнэ гэж бид ярьдаг. Тэгвэл 1990-ээд онд моодонд орж байсан том куртка энэ өвлийн загвараар эргэн ирлээ. Өмсөхөд эвтэйхэн, дотуур нь хэдэн ч давхар хувцас өмсөж болдгоороо чөлөөт загварт дурлагчдад илүү тохиромжтой.



Өвлийн жаварт бидний өмссөн хувцасны гадар хөлдөж, хуурайшин, хүрэхэд хэт эмзэг болсон байдаг. Тийм ч учраас аль болох зөөлөн материалтай хувцас өмсөхийг тэмүүлдэг. Харин хэт мэдрэг арьстай хүмүүс яг л чихмэл тоглоом мэт зөөлөн үстэй тод өнгийн хүрмээс сонголтоо хийвэл тохиромжтой. Эдгээр хүрэм харахад хүнд мэт боловч өмсөхөд маш хөнгөн.

Хувцас сонгохдоо хамгийн түрүүнд өнгөнд анхаарлаа хандуулах нь тодорхой. Энэ жилийн үндсэн өнгө бол улбар шар, хөх, улаан, хүрэн. Харин материалын тухайд хөвөн мэт зөөлөн үслэг болон хонины ноосон хүрэм трэнд болж байна. Чимэглэл багатай бөгөөд ханцуй болон хүзүүний хэсгээр бүчтэй эсвэл хүрэмтэйгээ ижил өнгийн товчтой байх аж.



ДЭЛХИЙН ЗАГВАРЫГ МОНГОЛООС



Моод Монголоор дуусна гэх ойлголт аль хэдийн ард хоцорсон. Үүний баталгаа бол Монголын нэрд гараад байгаа хувцас загварын төвүүдийн коллекцууд. Дотоодын брэндүүд энэ өвлийн трэнд болж буй хувцсыг үндэсний хэв шинжтэй хослуулан үйлдвэрлэж эхэлжээ. Энэ жилийн Нью-Йоркийн загварын долоо хоногээр хонины сайжруулсан үстэй гадуур хүрэмний коллекц худалдан авагчдын сонирхлыг ихэд татсаныг онцлох нь зүйтэй байх.



Хямд үнэтэй хэрнээ ямар ч насны хүмүүс өмсөхөд тохиромжтойгоор олон сонголттой, баруунд ноёрхож буй хувцасны хэв шинжийг агуулсан хувцсыг “Exclusive Mongolia”-гийн бүтээгдэхүүнээс харж болно. Энгийн, дэгжин энэхүү загварын гол чимэг бол ханцуй болон хүзүүний бүч.



Бидний сайн мэдэх “Дархан нэхий” компани өвлийн шинэ загвараа худалдаанд гаргаад байна. Тэдний голлох өнгө шар, цэнхэр бөгөөд хажуугаараа уул, үүл болон луун хээтэй торго оруулснаар үндэсний хэв шинжийг загвартаа шингээжээ.



Парисын загварын долоо хоногээр хонины үсэн хүрэм үнэхээр дэгжин харагдаж байв. Мэдээж хонины үс Монголд хамгийн тохиромжтой нь. Тиймээс дэгжин загварлаг хувцас урладаг “Michel and Amazonka” энэ өвлийн трэнд хувцсандаа үүнийг шингээж өгсөн нь монголчуудын сонгох хувцасны нэгд зүй ёсоор тооцогдож байна.

Өвлийн хувцас дулаан, дэгжин, хөнгөн байвал худалдан авагчдыг ихээр татдаг. Угааж цэвэрлэхэд хялбар, сайн чанарын материалаар хийгдсэн “Ангар” брэндийн куртка размерын өргөн сонголттойгоор худалдаанд гарчээ. Чанарын хувьд олон улсын Zara, Only брэндийн хувцаснаас дутахааргүй бөгөөд үнийн хувьд харьцангуй хямдаар худалдаалагдаж байгаа юм.



© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Шалгарсан хотууд Amazon-ыг гурван тэрбум ам.доллараар урамшуулна

Amazon компанид Нью-Йорк, Виржини, Теннесси-гээс амалж буй санхүүгийн урамшуулал гурван тэрбум ам.доллар давлаа. >10

Uber-ийн орлогын өсөлт гуравдугаар улиралд саарав

Uber зах зээлээ алдахгүйн тулд хүнс хүргэлт, хоёр дугуйт тээврийн хэрэгсэлд аварга хөрөнгө хаяж байна. >10

Булангийн орнуудын эдийн засаг сэргэж эхэлсэн ч эмзэг хэвээр

Газрын тосны үнэ 60 орчим хувиар өссөн нь Булангийн орнуудын эдийн засаг сэргэхэд таатай нөлөөлөв. >10

Бангладеш оёдлын салбарт Хятадыг орлож чадах уу



BVM©

оны дөрвөн хувиас 2016 онд 6.3 хувьд хүргэснийг ДХБ-ын мэдээнд дурдсан байдаг. Гэвч Хятадын 34.5 хувийн хэмжээнээс нэлээд зайтай агаад Вьетнам, Итали, Энэтхэгтэй ойролцоо юм.

Ази даяар цалин хөлсний хэмжээ өсөж буйн зэрэгцээ Бангладешийн хөдөлмөрийн аюулгүй байдал томоохон бэрхшээл үүсгэдэг. 2012 онд нэг үйлдвэрт гал гарч 117 хүн шатсан. 2013 онд үйлдвэрийн барилга нурахад 1100 хүн амиа алдсан. Иймээс өрнөдийн импортлогчид аюулгүй байдлын журмын тухай сертификат аваагүй бол Бангладешийн үйлдвэрээс бүтээгдэхүүн худалдан авахаас татгалздаг болсон юм. Гэхдээ Хятадад хөдөлмөрийн хөлс нэмэгдэж, АНУ-ын худалдааны маргаан үүсээд буй үед тус улс оёдлын үйлдвэрлэлд Хятадыг орлож чадах нэг номерын орон гэж Олон улсын хөдөлмөрийн байгууллага үнэлжээ.

Тус улс Хятадаас даавуу болон бусад зүйлийг авч, зөвхөн оёх, сүлжих үйл ажиллагаагаар дагнадаг. Материалын үнэ хувцасны борлуулалтын үнийн 65-70 хувийг эзэлдэг учир Бангладеш ирдэг ашиг тун бага. Японы Нэхмэл бүтээгдэхүүн импортлогчдын холбооны судлаач Ёшиаки Камияма "Бангладеш оёхоос өөр зүйл хийж чадахгүй бол яваандаа хямд өртөгтэй Этиопт байр сууриа алдана. Иймээс инновац шаардлагатай. Зөвхөн оёдлоос гадна хувцасны салбарын өөр чиглэлээр ур чадвараа дээшлүүлэх ёстой" FT хэмээн сануулсан байна.

Ноён Жаяакоди "Бид автоматжуулалтад их мөнгө зарж байгаа... Бангладеш цаашдаа хямд өртөгтэй улс байхаа болино" хэмээн ярилаа. Тус улс Камбож, Вьетнам, Мьянмар болон Африкийн Этиоп зэрэг улсын өрсөлдөөн ширүүсч байгаа үед Хятадын дараах дэлхийн хоёр дахь том хувцас экспортлогчийн байр сууриа хадгалахыг эрмэлзэж байна.

Жишээ нь, Uniqlo брэндийг Японд борлуулдаг Fast Retailing компани Африкийн орнуудад үйлдвэрлэлийн баазтай болохыг зорьж байгаа аж. Бангладешийн Хувцасны үйлдвэрлэл, экспортын холбооны мэдээгээр өрсөлдөөний шахалтаас сүүлийн таван жилд оёдлын үйлдвэрийн тоо 22 хувиар цөөрч, 4560 болсон нь томрох хандлагын илрэл юм. Өрсөлдөөнд

Бангладешийн бэлэн хувцасны экспорт



Жилдээ зургаан хувь өсөж буй Бангладешийн эдийн засгийн гол хөдөлгөгч хүч нь оёдлын салбар.

тэсэж үлдсэн нь гадаад руу өргөжиж, хувьцаагаа гаргахар төлөвлөж буй.

Жилдээ зургаан хувь өсөж буй Бангладешийн эдийн засгийн гол хөдөлгөгч хүч нь оёдлын салбар. Зургадугаар сараар төгсгөл болсон

тайлангийн жилд хувцасны экспорт 30.6 тэрбум ам.долларт хүрч, 8.8 хувь нэмэгдсэн ба тус улсын нийт экспортын 83.5 хувийг эзэлсэн байна. Түүнчлэн Бангладеш дэлхийн хувцасны экспорт дахь хувь хэмжээгээ 2010

Levi Strauss жийнсээ Уол Стритэд авчрахаар төлөвлөжээ

Николь Баллок

Цэнхэр жийнсийг анх бүтээсэн Levi Strauss компани буцаад Уол Стритийн санхүүгийн зах зээлд гарах санаатай байна. Эднийг анхны нээлттэй арилжаагаар 600-800 сая ам.доллар босгож, үнэлгээгээ таван тэрбумаас дээшлүүлэхээр тооцож байгааг учир мэдэх хоёр эх сурвалж ярилаа. Levi ирэх оны эхний улиралд IPO хийхээр төлөвлөсөн нь дараа жил хувьцаагаа худалдах хуучны брэндүүдийн тоог нэгээр нэмлээ. Сан Францискод

Levi ирэх оны эхний улиралд IPO хийхээр төлөвлөсөн нь дараа жил хувьцаагаа худалдах хуучны брэндүүдийн тоог нэгээр нэмлээ.

төвтэй тус компани Америкийн шүтээн болсон алдартай брэнд бөгөөд 1873 оноос цэнхэр жийнс үйлдвэрлэж эхэлсэн гэж үздэг.

Компанийн вебсайтаас уншихад өнөөдөр рок одоос эхлээд ухаалаг захирлуудын өмсөж буй хөх өмдийг Levi Strauss-ын оёдолчин Жеков Дэвис баруун эрэгт байрладаг бизнесийн байрандаа зохион бүтээсэн байна. Түүний гэр бүлийн Нью-Йоркт төвтэй хуурай хэрэглэлийн компани баруун эрэгт салбартай байжээ. Төмөр кноптой өмд эдлэгээ даах чадвартай байсан

тул АНУ-ын патент авсан гэдэг.

Одоо Levi Strauss-ын бүтээгдэхүүн дэлхийн 110 гаруй улсад зарагдаж, 2017 оны санхүүгийн жилд таван тэрбум ам.долларын орлоготой ажилласан нь өмнөх жилээс найман хувь өссөн үзүүлэлт. Наймдугаар сарын 26-нд дуусгавар болсон гурван сард эдийн орлого 1.4 тэрбумд хүрч, 130 саяын ашиг олжээ. Тус компани JPMorgan Chase, Goldman Sacks банкуудыг хөлслөн авч, нээлттэй хувьцааны зах зээлд гарах гэж байгааг эх сурвалжууд

мэдээлсэн. Урьд нь 1971 онд нээлттэй арилжаа хийсэн боловч гэр бүлийн өв залгамжлагчид буцаан хувийн компани болгосон юм.

Дээрх хоёр банк уг асуудлаар тайлбар өгөхөөс татгалзсан бөгөөд Levi Strauss мэдэгдэлдээ "Бид зах зээлийн цуурхал, элдэв яриаг тайлбарлахгүй" гэсэн байна. Хэрэв эдийн ирэх онд нээлттэй зах зээлд гарвал баруун эргийн Uber, Lyft зэрэг унаа дуудах үйлчилгээний томчуудтай зэрэгцэн IPO хийх төлөвтэй байгаа юм. FT

Технологийн дэвшил рүү хүүхдийг хөтлөх нь

Адриан Жозеф

Нэг, хоёр, дөрөв, найм, 16. Энэ бол дэлхийг өөрчилсөн тоонууд. Компьютерийн кодын хоёрлосон системийг илтгэх эдгээр тоон дарааллын хоёрор үржигдэх хязгаар байхгүй. Кодлоход мөн нэгийн прогресс хязгааргүй. Дөрөв, найм, 16 гэсэн тоогоор илэрхийлсэн харьцаанаас Британийн хүн амын бүтцийн статистик харагддаг. Тухайлбал, Британийн бага сургуулийн сурагчдын дөрөвний нэг нь хар арьст, ази гаралтай буюу үндэсний цөөнх (BAME гэж товчилдог). Ажиллах хүчин дээр энэ харьцаа наймны нэг байдаг бол захирлуудын зөвлөлийн гишүүдийн түвшинд 16-ны нэг болж цөөрнө.

Боловсрол ба бусад саад бэрхшээлийн улмаас BAME технологийн салбарт бүр ч цөөн оролцдог гэж бодож байна. Энэ бүлгийн хүүхдүүд голдуу ядуу гэр бүлээс гаралтай агаад Russel хэмээх жагсаалтад багтдаг дээд зэрэглэлийн их сургуулиудад



элсэх боломжгүй. Иймээс тэд тэргүүлэх технологийн компанид орох магадлал бага. Энэ байдлыг өөрчлөх шаардлагатай байна. Би өөрөө энэ статистик доторхуу руу чиглэсэн миний зам амар байгаагүй. Хорин хэдтэй байхад аав маань нас барж, дөнгөж эхэлсэн бизнес нурсан тул буцаад сурах хэрэгтэй болсон.

Ингээд хиймэл оюун ухаан, өгөгдлийн салбарт ажилладаг болон хойноо би эконометрик, статистик болон цэвэр матема-

тикийн ухаан технологийн өөрчлөлтийг хэрхэн дэмждэгийг ухаарч байна. Хиймэл оюун ухаан бидний амьдралын хэв маягийг бүрэн өөрчлөх ба инновацын аяллын алхам бүр нь суурь шинжлэх ухаанд тулгуурладаг. Математикийн хичээл болон шинэ технологийн холбоо залууст илт харагдахгүй ч BAME бүлгийн сурагчдын технологи руу нэвтрэх замын хаалтыг арилгах хэрэгтэй. Тэдний гэр бүлд хүүхдээ нябо, хууль, эмч болгохсон гэх мөрөөдөл зонхилдог.

Уг бүлгийн хүүхдэд технологийн

BAME бүлгийн сурагчдын технологи руу нэвтрэх замын хаалтыг арилгах хэрэгтэй.

боломжийг эртнээс таниулах ёстой. Хүүхэд амьдралыг нь тодорхойлох үндсэн шийдвэрийг 7-9 насны хооронд гаргадаг. Энэ насандаа тэд технологи, шинжлэх ухаанаас холдох буюу технологи мэддэг, дуртай хүмүүсээс урам зориг авч болно. Өнөөдөр компьютерийн ухааныг сургуульд түлхүү оруулах шаардлагатай боловч технологийн салбарынхан үүнээс цааш ахиулж, дадлага, дагалдангийн хөтөлбөр, сурталчилгааг ажил зохион байгуулах нь зүйтэй.

Британид BAME бүлгийн хэрэглэгчид жилдээ 300 тэрбум фунт зарцуулдаг атал байгууллагууд уг давхаргын бизнесийн боломжийг бүрэн тооцож чадахгүй байна. Технологийн салбар эхний сайн алхмууд хийсэн боловч цааш ахиу хэрэгтэй. Миний зөвлөмж бол энэ бизнесийн удирдах хүмүүс дөрөв, найм, 16-гийн харьцаан дахь BAME-гийн залуусыг уриалж, урагш хөтлөх цаг нь болжээ. FT

► Британийн танхим Брекситийн төслийг дэмжлээ



Жорж Паркер

Британийн Ерөнхий сайд Тереза Мэй таван цаг үргэлжилсэн танхимын хуралдаанаар Брекситийн хэлцлийг дэмжүүлж чадсан байна. Гэвч одоо уг төслийг парламентаар батлуулах хамгийн ярвигтай тэмцэл үлдээд буй. Тэрбээр сайд нарын танхим түүний саналыг удтал хэлэлцсэний эцэст дэжихээр болсныг мэдэгдэв. Гэвч парламент дахь өөрийнх нь намын зарим гишүүдээс хатуу шүүмжлэл ирж магадгүй. Ерөнхий сайд уг шийдвэрийг гаргахын тулд маш нарийн хэлэлцэж, намын удирдлага дахь байр суурийг нь ганхуулж болзошгүй үгүйсгэсэнгүй. Эрх баригч консерватив нам дотор Брекситийн асуудлаар санал зөрөлдөөн үүссэн тул хатагтай Мэй огцрох эрсдэлтэйг ажиглагчид тэмдэглэсэн байна.

► Грекийн төрийн албан хаагчид жагсав



Керин Хоуп

Грекийн төргийн албан хаагчид лхагва гарагт 24 цагийн ажил хаялт зарлаж, цалин ба тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхийг шаардлаа. 2010 оноос хойш олон улсаас гурван удаа хэрэгжүүлсэн тусламжийн хөтөлбөрийн дараа иргэдийн бодит орлого нэлээд буурсан. Наймдугаар сард тусламжийн хөтөлбөр дууссанаас хойш анх удаа Үйлдвэрчний эвлэлүүд томоохон ажил хаялт зарлаж, барилгачид болон цахилгаан сүлжээний ажилтнууд жагсаалд оролцов. 500 мянган төрийн албан хаагчид нэгтгэдэг ADEDY Үйлдвэрчний эвлэл тусламжийн хөтөлбөрийн үед баталсан хуулиудыг зөвлөрүүлж, тэтгэврийн шинэчлэл хийх, хэт хэмнэлтийн бодлогоос татгалзах болон ажилчдын эрх ашгийг хүндэтгэхийг уриалжээ.

► Чехийн Ерөнхий сайдад үл итгэх асуудал сөхөгджээ



Жеймс Шоттер

Чехийн Ерөнхий сайд Анджей Бабиш хүү нь оролцсон луйврын хэргийн улмаас ихээхэн шүүмжлэлтэй тулгараад байна. Европын холбооноос авсан татаасын мөнгөөр парламентын байр барихдаа буруу зарцуулсан хэрэгт тэрбумтан Бабишийг өнгөрсөн онд буруутгаж байв. Гэтэл саяхан Ерөнхий сайдын хүү дээрх хэрэгт гэрчээр дуудагдахгүйн тулд Крым рүү явсан тухай бичлэг дэлгэгдсэн явдал ихээхэн шуугиан дэгдээлээ. Ноён Бабиш энэ талаар ярихдаа сэтгэцийн өвчтэй хүүг нь сэтгүүлчид хоргоосор элдвийг хэлүүлсэн байна хэмээн няцаажээ. Гэвч Чехийн парламентын зарим гишүүн Ерөнхий сайдад үл итгэх асуудлаар санал хураах нөхцөл байдал үүссэн хэмээн мэдэгджээ.

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.


Шэннон Бонд, Жошуа Шаффин

Хоёр дахь төв оффисоо байгуулах газрыг 14 сар хайсан Amazon компанид Нью-Йорк хот, Виржини, Теннесси муж улсаас амлаж буй санхүүгийн урамшууллын хэмжээ гурван тэрбум ам.доллар давлаа.

Энэхүү мөнгө нь эдийн засгийн томоохон цараатай хөтөлбөрийн төлөө өрсөлдөгч Умард Америкийн бусад хотуудын амласнаас бага. Мэрилэнд, Нью-Жерси хоёр Сизтл дэх Amazon-ы төв байртай “эн тэнцүү эрх бүхий” шинэ оффисыг байрлуулахын төлөө татварын хөнгөлөлт эдлүүлэх зэрэг олон сайхан нөхцөл амласны нийт өртөг тус бүр долоон тэрбум ам.доллар давсан юм.

Гэтэл Amazon компани таван тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт, 50 мянга гаруй шинэ ажлын байрыг Виржини муж улсын Арлингтоны ойролцоох Кристал Сити, Нью-Йоркийн Квинсигийн ойролцоох Лонг Айленд Ситид хуваахаар шийдсэнээ мягмар гарagt мэдэгдлээ.

Программ хангамж хөгжүүлэгч шилдэг мэргэжилтэн зэрэг нарийн ур чадвартай ажиллах хүч дайчлахад илүү тохиромжтой байснаас ийм сонголт хийснээ



BBM©

1.53 тэрбум ам.долларыг хариу шагнал болгохоор амласан юм. Үүнд нэг ажлын байрыг ирэх 10 жилд 48 мянган ам.доллараар тооцсон нийт 1.2 тэрбум ам.долларын татварын хөнгөлөлт багтаж байгаа. Мөн ирэх 10 жилд Amazon-оос ихэсгэх ажлын байртай холбоотойгоор 325 сая ам.долларын урамшуулал олгоно. Ирэх 15 жилд ажлын байраа 40 мянгад хүргэж чадвал энэ урамшуулал 505 сая ам.доллар болж өснө.

Виржини муж улсад тус компани 25 мянган ажлын байр үүсгэснийхээ төлөө 573 сая ам.долларын урамшуулал авна. Үүнд нэг ажлын байранд 11 жилийн турш 22 мянган ам.доллараар тооцсон ажиллах хүчний тусламжийн 550 сая ам.доллар багтаж байгаа. Дээр нь Арлингтон хотын зочид буудлын татвараас орох 23 сая ам.долларын тусламжийн мөнгө мөн орно. Amazon 2038 он гэхэд ажиллах хүчээ 37850-д хүргэх тохиолдолд тус муж улсын урамшуулал 750 сая ам.долларт хүрнэ.

Шинэ оффисын ойролцоох Метро өртөө, явган хүний замын дэд бүтцийг сайжруулахад Виржини муж улс, Арлингтон

Шалгарсан хотууд Amazon-ыг гурван тэрбум ам.доллараар урамшуулна

цахим худалдааны компани тайлбарлаж байна.

“Энэ хоёр байрлал нь дэлхийн түвшний авьяас чадварнуудыг татах замаар олон жилд үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд тохирсон шинэ санаачилга үүсгэж хөгжүүлэх

суурь болно” хэмээн Amazon-ыг үндэслэгч, гүйцэтгэх захирал Жефф Безос өгүүлсэн юм.

Amazon компани Теннесси муж улсын Нэшвиллд 5000 ажлын байр бүхий арай жижиг оффис нэмж байгуулахаар болсноо мөн мягмар гарagt мэдээллээ.

Тус компани 150 мянга гаруй ам.долларын дундаж цалинтай олон арван мянган ажлын байр шинээр үүсгэж буйнхаа төлөө санхүүгийн дорвитой урамшуулал хүртэнэ. Арлингтон, Лонг Айленд Ситид дор хаяж 25 мянган ажлын байр

шинээр үүсгэх үүрэг хүлээсэн Amazon компани хожим тус бүрийг нь 40 мянгад хүргэж өсгөхөөр эрх баригчидтай тохиролцожээ.

Энэхүү сүүлийн тохиролцоо ажил хэрэг болох аваас хот, муж улс хоёроос Amazon-д үзүүлэх


урамшуулал гурван тэрбум орчим ам.доллар болох тооцоог Нью-Йоркийн захирагч Эндрю Куомо гаргалаа.

Ирэх 10 жилд 25 мянган ажлын байр үүсгэж, шинэ оффисын байрыг дүүргэх тохиолдолд Нью-Йорк муж улс Amazon-д

тойрог нэмж 223 сая ам.долларын хөрөнгө оруулна. Amazon-д ложистикийн салбарынхаа шинэ оффист 5000 ажлын байр үүсгэж өгсний хариуд Теннесси муж улс, Нэшвил хот 102 сая ам.долларын хариу барьж байна.



Uber-ийн орлогын өсөлт гуравдугаар улиралд саарав



Шэннон Бонд

Ирэх жил хувьцаагаа нээлттэй арилжаа гэж буй такси шеринг үйлчилгээний компани бизнесээ хоол хүргэлт, унадаг дугуй, скутер зэрэг олон салбарт төрөлжүүлж буйтай уялдан орлого өсөх хурдац нь гуравдугаар улиралд эрс саарав.

Uber-ийн үндсэн бизнес унаа дуудах үйлчилгээнд ч дарамт шахалт ихэссэн тул санхүүгийн хувьд тэнхээжсэн өрсөлдөгчдөөсөө зах зээлээ хамгаалах шаардлага тулгараад байна. Гуравдугаар улиралд тус компанийн цэвэр орлого жилийн өмнөх үеэс 38 хувиар сайжирч, 2.95 тэрбум ам.доллар боллоо. Uber-ийн орлого энэ

оны нэгдүгээр улиралд 70, хоёрдугаар улиралд 63 хувиар өсөж байсантай харьцуулахад энэ нь сул үзүүлэлт. Хоёрдугаар улиралтай харьцуулахад орлого ердөө таван хувиар өссөн байна.

Зардлаа танасны ачаар жилийн өмнө 1.46 тэрбум ам.доллар байсан цэвэр алдагдал 1.07 тэрбум болж буурлаа. Гэхдээ хоёрдугаар улиралд зардал 1.07 тэрбум болж буурлаа. Гэхдээ хоёрдугаар улиралд зардал 1.07 тэрбум болж буурлаа. Гэхдээ хоёрдугаар улиралд зардал 1.07 тэрбум болж буурлаа.

Шинэ онд хувьцаагаа анх удаа нээлттэй арилжихаар бэлтгэж буй Uber орлогогүй ажилладаг такси шеринг компани төдий бус гэдгээ боломжит хөрөнгө оруулагч нартаа ойлгуулахаар чармайж байна. Банкууд тус компанийн

үнийг 100 тэрбум ам.доллар давна хэмээн тооцоолжээ. Гүйцэтгэх захирал Дара Хосровшахи зардал танасны ачаар Uber-ийн санхүүгийн сахилга сайжирсан. Компани бусад салбарт хөрөнгө оруулах шаардлагатайг захирал анхааруулсан нь ирэх оны IPO-гоос өмнө орлоготой ажиллах боломжгүй гэсэн хэрэг болов.

Uber нь төрөлх АНУ болон хилийн чанадад зах зээлээ алдахгүйн тулд хүнс хүргэх үйлчилгээ, хоёр дугуйт тээврийн хэрэгсэлд аварга хөрөнгө хаяж байна. Дээр нь автомат жолоодлогот машины технологи хөгжүүлэхэд ч үлэмж мөнгө урсгаж ирлээ. “Манай бизнесийн хэмжээ, цар хүрээнд тохирсон дахиад нэг даацтай улирал өнгөрлөө. IPO-гийн өмнөх бэлтгэл болгон хүнс, ачаа тээвэр, цахилгаан моторт унадаг дугуй, скутерт хөрөнгө оруулж байна. Дээр нь Энэтхэг, Ойрх Дорнод зэрэг өсөх боломж сайтай зах зээлд тэргүүлэх байр сууриа хадгалж ажиллана” хэмээн Uber-ийн санхүү хариуцсан захирал Нельсон Чай мэдэгдэв.

Орлого өсөх хурдац саарсан нь хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалж байна. Uber идэвхтэй ажилладаг Латин Америкийн зах зээлд ам.долларын ханш чангарч, шинэ бизнес эрхлэх болсноос орлогын эх үүсвэр өөрчлөгдсөн нь өсөлтийн хурдац саарахад хүргэжээ. Жолоочийн төлбөр, сурталчилгаа, нөхөн төлбөр, Засгийн газрын татвар зэргийг төлөхөөс өмнөх нийт орлого жилийн өмнөх үеэс 34 хувь өсөж, 12.7 тэрбум ам.долларт хүрсэн нь хоёрдугаар улирлын 41, нэгдүгээр улирлын 55 хувийн өсөлтөөс эрс бага байна.

Хүнс хүргэх Uber Eats салбарын орлого 2.1 тэрбум ам.доллар болсон нь нэгдүгээр улирлынхаас 40, жилийн өмнөх үеийнхээс 150 хувь өссөн үзүүлэлт болв.



BBM©

Булангийн орнуудын эдийн засаг сэргэж эхэлсэн ч эмзэг хэвээр

Симеон Керр

Газрын тосны үнэ боломжийн өсөж, олборлолт ихэссэний ачаар Булангийн араб орнуудын эдийн засаг энэ онд өсөлттэй гарна хэмээн Олон Улсын Валютын Сан (ОУВС) мэдэгдлээ. Гэхдээ өсөлтөд сэтгэл хангалгүй, газрын тосны үнэ тогтворгүй байгаа үед эдийн засгийн шинэчлэлээ эрчимтэй өрнүүлэх ёстойг тус байгууллага нэмж анхааруулав.

Хоёр жилийн өмнө 0.4 хувь буурсан Булангийн Хамтын Ажиллагааны Зөвлөлийн (GCC-Gulf Cooperation Council) гишүүн орнуудын эдийн засаг бүс нутгийн намрын эдийн засгийн тайландаа гаргажээ. Газрын тосны үнэ сүүлийн хоёр жилд 60 орчим хувиар өссөн нь тус зөвлөлийн гишүүн улсуудын эдийн засаг сэргэхэд таатай нөлөөлөв. Үнэ уналтаас үүдэн Булангийн орнууд татаас багасах, шинээр татвар үүсгэх зэргээр төсвөө

тодотгож Засгийн газрын зардлаа танаад байсан юм. Гэтэл дунд хугацаандаа газрын тосны үнэ баррель нь 65 орчим ам.долларт эргэн буусан нь ажилгүйдлийн бэрхшээл, нефтис хараат байдлаа багасгах шинэчлэлийн хөтөлбөрөө эрчимжүүлэх шахаалт болж буйг ОУВС-гийн бүс нутгийн захирал Жихад Азур анхааруулав. “Газрын тосны үнийн эрс өөрчлөлт бүс нутгийн орнуудад тайвшрах болоогүйг ойлгууллаа. Шинэчлэлийн цар хүрээг цаашид улам өргөжүүлэх ёстойг энэхүү үнийн уналт харуулж өглөө” хэмээн захирал өгүүллээ.

Ираны эсрэг хориг сэргэсэн нь дэлхийн нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлнө гэсэн айдсын улмаас есдүгээр сард газрын тос баррель нь 80 ам.доллар давсан. Гэтэл Иранаас газрын тос худалдан авагч гол улсуудыг хориглоос чөлөөлсний зэрэгцээ эрэлт буурах хандлагатай болсноос шалтгаалж зах зээл буцаад суларлаа. Өнгөрсөн сард сэтгүүлч Жамал Хашогтийг

хөнөөсөн хэрэг Булангийн орнуудын эдийн засагт нөлөөлөх харахан болоогүйг ноён Азур анхааруулж байна. Сэтгүүлчийг хөнөөсний улмаас олон улсын тавцанд шүүмжлэл дэгдэж, Саудын Арабын вант улс цаашид гадаадын шууд хөрөнгө оруулалт татаж чадах эсэх нь эргэлзээтэй болсон юм.

Булангийн орнууд дан газрын тосонд тулгуурлалгүй, эдийн засгаа олон салбарт төрөлжүүлэхийн тулд боловсрол, дэд бүтцийн хөрөнгө оруулалтаа ихэсгэх замаар жижиг, дунд компаниудыг дэмжих ёстойг ноён Азур тайлбарлав. Хувьчлалыг эрчимтэй өрнүүлж, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх нь цаашид хувийн салбар хөгжин цэцэглэх нөхцөл болно хэмээн тэрбээр нэмж өгүүлсэн юм. Эмэгтэйчүүдийг ажлын байранд татан оролцуулах зэргээр Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмиратын эдийн засгийн шинэчлэлт зөв чиглэлд өрнөж буйг ноён Азур дурдаж байлаа.



Эдийн засаг

Финтек бол ББСБ-ын ирээдүй

ББСБ-уудын нийт хөрөнгийн өсөлт хэрэглээний зээл нэмэгдсэнтэй холбоотой

Ч.Баатар
ЗГМ

Сүүлийн зургаан жилд банк бус санхүүгийн байгууллагын нийт хөрөнгийн хэмжээ тасралтгүй өсжээ. Энэ талаар “Инвестор” ББСБ-ын гүйцэтгэх захирал Д.Баясгалантай ярилцлаа. Тэрбээр салбарын нийт хөрөнгийн хэмжээ нэмэгдэхэд манай улсын эдийн засгийн макро орчин харьцангуй тогтвортой байгаа нь голлон нөлөөлснийг онцоллоо. Мөн банк бус санхүүгийн байгууллагууд финтект суурилсан үйлчилгээ үзүүлж эхэлснээр зардлаа бууруулах боломжтой гэв.

–Энэ оны хувьд танай салбарт зах зээлийн өсөлт хэрхэн мэдрэгдэж байна вэ?

–Энэ оны эхний гурван улирлын тоон мэдээллээс харахад банк бус санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн нийт хэмжээ 1.2 их наяд төгрөгт хүрсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 30 гаруй хувиар өссөн үзүүлэлт. Үүн дотор зээлийн өсөлт илүү давамгайлж байна. Үүнийг манай улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүд харьцангуй тогтвортой байж, эдийн засгийн суурь түвшин сайжирсантай холбоотой гэж харж байна. Гэхдээ дан ганц эдийн засгийн тогтвортой байдал бус финтект суурилсан аппликейшнууд олноор гарч, бичил зээл буюу бага дүнтэй хэрэглээний зээл нэмэгдсэнтэй холбоотой.

–Зах зээл дэх хүүгийн түвшин цаашид яаж өөрчлөгдөх тө-



Манай компанийн хувьд хиймэл оюун ухаанд суурилсан credit scoring-ийг хөгжүүлэхээр төлөвлөд байна.



лөвтэй байна вэ?

–Зээлийн хүү буурсаар л байгаа. Жишээлбэл, 2016 онд зээлийн сарын дундаж хүү 4-4.5 хувь байсан бол 2018 онд энэ тоо гурван хувьд хүрсэн. Өөрөөр хэлбэл, хоёр жилд 1.5 хувиар багассан гэсэн үг. Энэ байдал цаашид ч үргэлжилж, зээлийн хүү буурах хандлагатай байна. Гэхдээ энэ нь улсын эдийн засаг хэр тогтвортой байхаас хамаарна. Банк бус санхүүгийн байгууллага нь өөрсдийн эх үүсвэрээс эсвэл гаднаас хөрөнгө татаж, дотоод-

доо эргэлдүүлдгээрээ банкнаас ялгаатай. Гаднаас авах санхүүжилт мэдээж гадаад валютаар орж ирдэг. Үүнд төгрөгийн ханшийн тогтвортой байдал хамгийн их нөлөөлдөг учраас төгрөгийн ханшийн тогтвортой байдал зээлийн хүү бууруулахад маш чухал.

–Зардлаа бууруулах чиглэлд компаниуд ямар шинэчлэл хийж байгаа вэ?

–Финтект суурилсан үйлчилгээнүүд нэвтэрснээр дагаад хиймэл оюун ухаанд суурилсан Credit scoring-ийг хөгжүүлэхээр

Өнгөрсөн хоёр жилд зээлийн хүү 1.5 хувиар багассан

ирээдүйг технологийн шийдэл гэж харж байна.

Манай компанийн хувьд хиймэл оюун ухаанд суурилсан Credit scoring-ийг хөгжүүлэхээр

төлөвлөд байна. Үүнийг хөгжүүлснээр зээл олгоход шаарддаг олон бичиг баримт гэх мэт цаг алдсан шат дамжлага байхгүй болно. 2019 оны эхээр үр дүн бага багаар харагдаж эхлэх байх. Тэр үед зардал, цаашлаад зээлийн хүү буурна.

–Ирэх онуудад эдийн засгийн өсөлт үргэлжлэх төлөвтэй байна. Компаниуд үүнтэй холбоотой ямар төлөвлөгөө боловсруулж байгаа бол?

–Технологийн шийдлүүдээс гадна олон улсын зах зээлд гарахаар зорьж байна. Зүүн өмнөд болон Төв Азийн зарим орнуудын зах зээлийг онилж байна. Эдгээр улсын зах зээл их том. Түүнчлэн Монголын банк бус санхүүгийн байгууллагууд болон банкны өнөөгийн хөгжил тэдгээр улстай харьцуулшгүй өндөр түвшинд байгаа юм. Тийм болохоор манай улсын хувьд томоохон давуу тал, боломж байна. [ЗГМ]

ТӨЛӨВ БАЙДАЛ

ДНБ-ий өсөлт сүүлийн дөрвөн жилийн дээд түвшинд хүрлээ

Б.Бямбасүрэн
Шинжээч

2018 оны III улиралд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 6.4 хувиар өссөн гэж Үндэсний статистикийн хороо мэдээллээ. Дотоодын нийт бүтээгдэхүүн 2010 оны зэрэгцүүлэх үнээр оны эхний сард өмнөх оны мөн үеэс 0.8 их наяд төгрөгөөр өсөж, 12.8 их наяд төгрөгт хүрсэн байна. ДНБ-ий өсөлтийг үйлчилгээ болон татвар голлон бүрдүүлжээ. Тухайлбал, бүтээгдэхүүний цэвэр татвар 305.5 тэрбум төгрөг буюу 22.9 хувиар, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 349.2 тэрбум төгрөгөөр тус тус дээшилжээ. Ялангуяа, бөөний болон жижиглэн худалдаа 88.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Харин нүүрсний үнэ харьцангуй өндөр түвшинд байлаа.

Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн санхүүжилт орж ирсэн болон S&P агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг

өсгөсөн зэрэг эерэг үйл явдлуудаас улбаалан улсын эдийн засаг 6.4 хувиар өссөн байна. Энэ нь сүүлийн дөрвөн жилийн хамгийн өндөр үзүүлэлт болж буй аж. 2015, 2016 онд буураад байсан Монгол Улсын эдийн засаг 2017 оноос хойш дунджаар 5-6 хувиар өсөөд буй. Салбараар нь авч үзвэл, хөдөө аж ахуйн салбар 1.7, аж үйлдвэр, барилгын салбар 2.3, уул уурхайн олборлох салбар 0.6 хувиар тус тус дээшилжээ.


Энэ оны хагас жилд “Эрдэнэс Тавантолгой” компани 953 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна. Ингэснээр оны эхний хагаст төсөвт төвлөрүүлэх ёстой байсан орлогынхоо 78 хувийг бүрдүүлжээ. Тус компани энэ онд 13 сая тонн нүүрс экспортлохоор зориод буй бөгөөд есдүгээр сарын байдлаар 9.5 сая тонныг экспортлоод байна.

Мөн Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Говь” ХК-ийн борлуулалтын орлого оны эхний хагас жилд өмнөх оны

мөн үеэс 64 хувиар өсөж, 55.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Уул уурхайн салбар ийн идэвхжсэн нь үйлчилгээний салбар өсөхөд гол нөлөө үзүүлсэн гэж Үндэсний статистикийн хороо онцоллоо.

Үүнээс гадна аравдугаар сард инфляц 6.3 хувьтай гарлаа. Инфляцын өсөлтийн 40 орчим хувийг шатахууны үнийн өсөлт бүрдүүлсэн гэж УЦХ мэдээллээ. Тээврийн бүлгийн үнэ өссөн нь инфляцад нөлөөлсөн байна. Ялангуяа, хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ өссөн нь голлон нөлөөлсөн аж. Харин жилийн дүнгээр орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 11 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.7 хувиар өгссөн нь хамгийн өндөр өсөлт болж буй. Уул уурхайн бус салбарын идэвхжил болон цалингийн өсөлтийн нөлөөгөөр 2019 онд хүнсний бус инфляц өсөх бол 2020 онд эргээд буурах магадлалтай гэж Монголбанк Инфляцын төлөв байдлын тайландаа дурджээ.

ДНБ-ий өсөлт үйлдвэрлэлийн аргаар



Төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл
(сүүлийн таван жилийн V сард, тэрбум төгрөг)




ДУУДЛАГА ХУДАЛДАА

83.5 га газрыг дуудлагаар худалдана

Т.Дэмбэрэлням
Шинжээч

Нийслэлийн Газрын алба баасан гарагт буюу өнөөдөр нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулахаар болжээ. Газар эзэмших уг дуудлага худалдаагаар нийт 24 байршлын орон сууц, үйлдвэрлэл, худалдаа эрхлэх зориулалт бүхий 83.5 га газрыг худалдах аж. Эдгээр 24 талбайн хамгийн өндөр үнэлгээтэй нь “Чингис хаан” олон

улсын нисэх онгоцны буудлын урд байрлах үйлчилгээний зориулалттай таван га газар юм. Энэ газрыг дуудах хамгийн доод үнэ нь 784.4 сая төгрөг. Энэ онд таван дүүргийн 42 байршилд газар эзэмших, ашиглах эрхийн нээлттэй дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулах зарчмаар батлагдаж, нийслэлийн төсөвт 13.7 тэрбум төгрөг төвлөрүүлсэн талаар нийслэлийн Газрын албанаас мэдээлсэн. Өнгөрсөн гурван улирлын байдлаар газар эзэмших эрхийн



нээлттэй дуудлага худалдааг гурван удаа зохион байгуулж, таван байршилд 5.47 га газар худалдан, төсөвт 711.5 сая төгрөг

төвлөрүүлжээ. Мөн энэ оноос дуудлага худалдааг шинэчлэгдсэн үнэлгээний аргачлалын дагуу явуулж эхэлсэн. Өөрөөр хэлбэл,

дуудлага худалдааны анхны үнийг бууруулж, зах зээлийн үнэлгээнд ойртсон үнээр худалдах боломж бүрдсэн байна.

ЗГМ ТОВЧХОН

» БОНД

1

Тэрбум төгрөг. “Минжпропери” компани нэг жилийн хугацаатай нэг тэрбум төгрөгийн бонд гаргахаар болжээ. “Парк Таун” нэртэй гаргаж буй уг бондыг Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанаар үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн байна.

» АШИГ

3.4

Тэрбум ам.доллар. Хонконгийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй Tencent компанийн цэвэр ашиг өнгөрсөн улиралд 30 хувиар өсөж, 3.4 тэрбум ам.доллар хүрчээ. Харин борлуулалтын орлого нь шинжээчдийн таамгаас давж, 11.6 тэрбум ам.доллараар хэмжигдлээ.

» ИПОТЕК

33

Мянга. “Улсын төсвөөс санхүүжих орон сууцны хөнгөлөлттэй зээлийн журам”-ыг боловсруулж, Засгийн газарт өргөн барих гэж буй.

Урьдчилсан судалгаагаар урьдчилгаа 30 хувиар төлөөд зээлд хамрагдах боломжтой 33 мянган иргэн нийслэлд, харин 14 мянган иргэн орон нутагт байна.

» ТҮҮХИЙ ЭД

90.2

Ам.доллар. Дулааны нүүрсний фьючерс ханш Жинжоугийн Таваарын биржид лхагва гаргт дөрвөн хувиар өсөж, тонн нь 90.2 ам.долларт хүрлээ. Энэ нь 2017 оны гуравдугаар сараас хойших хамгийн өндөр өндөр үзүүлэлт юм.

» ГАЗРЫН ТОС

125.5

Сая ам.доллар. ОХУ-ын Lukoil компани түлш, шатахууны зах зээлд үнэ тогтворжуулах бодлогын хүрээнд сүүлийн дөрвөн сард 125.5 сая ам.долларын алдагдал хүлээжээ. Мөн тус компанийн газрын тос олборлолт ОПЕС-ийн хэлэлцээрийн хүрээнд зургадугаар сараас хойш өдөрт 30 мянган баррелиар нэмэгдээд буй. Улмаар газрын тосны нийт гарц нь энэ онд 86 сая тонноор хэмжигдэх төлөвтэй байна.

» АШИГ

806

Сая ам.доллар. Apple-ийн нийлүүлэгч, БНХАУ-ын Hon Hai Precision Industry буюу Foxconn компанийн цэвэр ашиг өнгөрсөн улиралд өмнөх оныхоос 18 хувиар өсөж, 806 сая ам.доллар хүрчээ. Гэсэн ч энэ нь шинжээчдийн таамгаас 12 хувиар бага үзүүлэлт аж.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2569.63
Евро	2,913.45
Японы иен	22.63
ОХУ-ын рубль	38.57
БНХАУ-ын юань	370.38
БНСУ-ын вон	2.28

Эдийн засаг

Бизнесүүд байгалийн гамшигийн улмаас 330 тэрбум ам.долларын алдагдал хүлээжээ



Эрсдэл өндөр бизнесийн орчинд өөрөөс хамаарах сорилт бэрхшээлүүдээ шийдэх нь чухал.

◀1
Одоогоос хэдэн жилийн өмнө Австралид үер буусны улмаас олон улсын зах зээлд нүүрсний үнэ гэнэт өсөж, сандарч явсан бид түүхий эдийн орлогоо санаандгүй нэмэгдүүлж байв. Арлын Австралид байгалийн гамшиг нүүрлэсэн нь талын Монголд ашиг авчирлаа хэмээн бид тухайн үед битүүхэндээ баярлаж байсан нь үнэн. Гэхдээ бидэнд үерт автсан Австралийн орд уурхайг ам дамжин ярихаас өөрөөр эрсдэлээс сэрэмжлэх, эртнээс бэлтгэх сөхөө үнэндээ байсангүй.

Гэтэл энэ оны зургаа болон долдугаар сарыг дамнан орсон борооноор манай экспортын гол зам сүйдсэнээс Монгол Улсын орлогын гол эх үүсвэр болсон нүүрсний нийлүүлэлтийг хэсэг хугацаанд гацаав. Ер нь өнгөрсөн зуны бороо манай уул уурхайн компаниуд ялангуяа, нүүрсний уурхайнуудын эрсдэлийн бэлэн байдлыг шалгасан. Гэвч дийлэнх нь гэнэтийн энэ шалгалтад бүдэрч, хэд хоног зутарчээ. Байгалийн гамшиг бидэнд ийнхүү сургамж үлдээлээ.

Ирэх жилүүдэд бэлэн байхыг сануулсан сургамжтай үйл явдал болсон. Тиймээс олборлогчид маань эртнээс эрсдэлийн удирдлагын менежментээ сайжруулах хэрэгтэй гэж эдийн засагч Л.Наранбаатар хэлж байна.

Эрсдэлийн менежментийн нэг хэсэг болох гамшигийн менежмент өнөө хэр манай хувийн хэвшилд үгүйлэгдэж байна. Учир нь дэлхийн байгаль цаг уурын хувьсал, өөрчлөлт, байгальтай зүй бус харилцаж буй хүний зохисгүй үйл ажиллагаанаас болж гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдээд байна. Эрдэмтдийн судалгаагаар дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн сүүлийн 60 жилд Монгол орны агаарын жилийн дундаж температур хоёр

градусаар нэмэгдэж, ган, зуд, байгалийн гамшигт үзэгдлийн давтамж ойртжээ.

Гэтэл НҮБ-ын тайланд дурдсанаар гамшиг болсны дараа бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөгүй аж ахуйн нэгжийн 75 хувь нь гурван жилийн дотор үүдээ барьдаг байна. Тухайлбал, Японы 100 жилийн түүхэнд хараар бичигдэх гамшиг 2011 онд тохиосон. Тус улсын баруун өмнөд хэсэгт болсон газар хөдлөлтөд өртсөн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн 30 хувь нь бизнесийн үйл ажиллагаагаа дахин эхлүүлээгүй байна. Жижиг бизнесүүдэд ийн нөлөөлсөн бол томоохон компаниуд ч хохирол амссан. Японы алдарт Toyota компани гэхэд энэ үеэр 1.2 тэрбум ам.долларын алдагдал хүлээж

байжээ. Тэгвэл өнгөрсөн онд дэлхийн бизнесүүд байгалийн гамшигийн улмаас 330 тэрбум ам.долларын алдагдал хүлээснийг Munich Re тайландаа дурджээ.

Байгалийн гамшгаас сэргийлж чадсанаар давуу тал олдог

“PMI Mongolia Chapter” төрийн бус байгууллага манайд эрсдэлийн удирдлага сул гэж дүгнэж байна. Энэ нь аж ахуйн

нэгж болон төслийн алдагдал өсөх нэг шалтгаан болдог байна. Тухайлбал, байгалийн гамшиг зэргийг багтаасан эрсдэлийн менежментийн алдагдал дэлхийн дунджаар 10 хувь байдаг бол Монголд 25 хувьтай байдаг аж. Барилгын компаниуд байгаль цаг уураас үүдсэн эрсдэлтэй нүүр тулах нь элбэг. Тухайлбал, цаг уурын эрс тэс байдлаас үүдэн технологийн асуудал үүсдэг гэж Premium Building Materials компани онцоллоо.

Манай улс төр, эдийн засгийн орчин тогтворгүй, тодорхойгүй. Энэ хэрээр бизнес эрхлэгчид өндөр эрсдэлтэй орчинд үйл ажиллагаа явуулсаар ирсэн. Өдгөө валютын болон таваарын ханшийн эрсдэл Монголын бизнес эрхлэгчдийн толгойны өвчин

хүчний агентлаг мэдэгдлээ. ОПЕС гарцаа нэмснээр улс орнуудын газрын тосны нөөц ихсэж, ханш буурч эхэлснийг тус агентлаг сарын тайландаа онцолжээ. Аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудад сүүлийн дөрвөн сар дараалан

газрын тосны нөөц өссөн байна. Хэрэв цаашид гарц өнөөгийн түвшинд хэвээр хадгалагдвал ирэх хагас жилд нөөц өдөрт хоёр сая барелиар нэмэгдэх төлөвтэй байна.

Олон улсын эрчим хүчний



агентлаг хөгжиж буй орнуудад ирэх онд газрын тосны эрэлт өмнө нь таамаглаж байснаас бага хувиар өсөх төлөвтэй гэж үзэж байна. Тиймээс эрэлтийн төлөвийг бууруулж, өдөрт 1.1 сая барелиар өснө гэж тооцоолжээ.

Shell, Petronas, Petrochina, Mitsubishi-гийн хамтарсан LNG Canada компанитай 576 сая ам.долларын хэлцэл хийжээ. 2014 оноос эхэлсэн уг хэлцэл ийнхүү шийдэлд хүрч байгаа аж.

Гэрээний хүрээнд LNG Canada 150 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар шинэ усан зогсоол барьж, 2020 оны гуравдугаар улиралд ашиглалтад оруулахаар тохиролцжээ.

Rio Tinto компани Kitimat усан зогсоолоор дамжуулан Бритиш Колумби муж дахь хайлуулах үйлдвэрээс хөнгөн цагаан тээвэрлэдэг юм.

Гамшигт өртсөн гурван жижиг бизнес тутмын нэг нь дампуурчээ



болсоор буй. Мөн технологийн хөгжлийн сүүдэр болсон мэдээллийн аюулгүй байдал ч хувийн хэвшлийнхний санааг зовоох болов. Улс төр, макро эдийн засгийн орчны сорилтоос энгийн бизнес эрхлэгч сэргийлж, хамаалах нь амаргүй. Харин эрсдэлээр дүүрэн бизнесийн орчинд өөрөөс хамаарах сорилт бэрхшээлүүдээ шийдэх нь чухал болохыг Удирдлагын академийн багш Ц.Өнөржаргал хэлж байна. Өөрөөр хэлбэл, бусад эрсдэлээс бизнесээ хамгаалах боломж тэдний гарт байна. 2008 оны дэлхийн эдийн засгийн их хямралын дараагаас бизнес эрхлэгчид эрсдэлийг эн тэргүүнд авч үзэж ирлээ. Байгалийн гамшиг хэний ч дайрахыг үгүйсгэхгүй. Гол нь уг эрсдэлээс сэргийлж чадсанаар өрсөлдөөнд ялах давуу талыг олж авдаг байна. [31]

Түүхий эд Газрын тосны нийлүүлэлт хангалттай түвшинд хүрсэн

М.Золбоо
Шинжээч

Газрын тосны зах зээлд нийлүүлэлт хангалттай түвшинд хүрсэн гэж Олон улсын эрчим

уул уурхай Rio Tinto усан зогсоолоо худалдлаа

Rio Tinto компани Канадын Бритиш Колумби муж дахь Kitimat усан онгоцны зогсоолыг худалдахаар болжээ. Мөн газраа түрээслэх хэлэлцээг эцэслэсэн байна. Тус компани

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:

АПУ ХК Өдөр ↓0.19% Сар ↑ Жил ↓	ГОВЬ ХК Өдөр ↓1.65% Сар ↑ Жил ↑	ТАВАН ТОЛГОЙ ХК Өдөр ↓4.9% Сар ↓ Жил ↑	СҮҮ ХК Өдөр ↑0.13% Сар ↓ Жил ↓				
Turquoise Hill Resources Ltd Торонто Өдөр ↑2.17% Сар ↑ Жил ↓	Erdene Resource Development Лондон Өдөр ↑2.08% Сар ↑ Жил ↑	Aspire Mining Австрали Өдөр ↑4.35% Сар ↑ Жил ↓	Rio Tinto Австрали Өдөр ↓0.31% Сар ↑ Жил ↓				
DOW JONES 0.68%	S&P 500 0.86%	FTSE 100 0.22%	NIKKEI 225 0.0062%	TOPIX 0.26%	SHANGHAI COMPOSITE 0.93%	HANG SENG 0.50%	KOSPI 1.19%